

(3) Мал маллагааны арга, технологийг сайжруулах төсөл

Мэдлэг туршлагагүй залуу малчид, малгүй болон цөөхөн малтай малчдад нүүдлийн мал аж ахуй эрхлэх арга туршлагыг зааж сургах (Малчид дундын сургалт) замаар "малчдын мал маллагааны арга технологийг сайжруулан дээшлүүлэхийг" зорино.

(4) Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх төсөл

Говийн бүсийн мал аж ахуйд хэд хэдэн төрлийн эрсдэл дагалдаж байдаг. Зунд болдог ган, өвөлд болдог зуд зэрэг гадны хүчин зүйлийг дагалдсан эрсдэл, халдварт өвчин, малын хулгай зэрэг эрсдэлээс хамгаалахын тулд "Эрсдэлийн менежментийн чадварыг бий болгох, бэхжүүлэх" зорилгыг энэ төлөвлөгөө агуулна. Эрсдэлийн менежментийг голлон хэрэгжүүлэгчид нь төв болон орон нутгийн засаг захиргаа, түүнчлэн малчид өөрсдөө байна.

3.4.3 Малчин өрхийн орлогыг тогтворжуулах бүрэлдэхүүн хэсэг

Энэ бүрэлдэхүүн хэсэг нь малчдын орлогын шинэ эх үүсвэрийг бий болгох, орлогыг тогтвортой болгох зорилгыг агуулах тул мал аж ахуй эрхлэлтийг сайжруулах (мал аж ахуйн менежментийг сайжруулах) төлөвлөгөө, мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах төлөвлөгөө гэсэн 2 төслөөс бүрдэнэ.

(1) Мал аж ахуй эрхлэлтийн менежментийг сайжруулах төсөл

"Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх ба жижиг бизнесийг хөгжүүлэх" зорилгыг агуулах энэ төслийн хүрээнд малчид мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, малчдын орлогын шинэ эх үүсвэрийг нээх арга замыг эрэлхийлнэ.

(2) Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах төсөл

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш нэгдэлийн (Хөдөө аж ахуйн хоршоолол) суурийг хоршоо залгаж, урьд нэгдэлийн үед байсан зах зээлийн ханган нийлүүлэлтийн систем алга болсон байна. Иймд "Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийн дэд бүтцийг бий болгох" нь мал аж ахуйн хөгжилд зайлшгүй чухал гэдэг үүднээс энэ төлөвлөгөөг боловсруулах шаардлага гарч ирж байна.

3.4.4 Хүний нөөцийг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг

Хүний нөөцийг хөгжүүлэх асуудлыг төсөл тус бүрээр авч үзнэ. Харин бүх төслийн хүрээнд технологийн сургалт, ажлын байран дахь сургалт зэргээр дамжуулан хүмүүсээ сургах зорилтыг тавих нь чухал юм. Ялангуяа зөвхөн хүний нөөцийг хөгжүүлэх төсөл болгон хэрэгжүүлэх боломжтой байна.

3.4.5 Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд ба төслүүдийн уялдаа холбоо


Дээр өгүүлсэн бүх бүрэлдэхүүн хэсгүүд болон төслүүдийн уялдаа холбоог дараахь хүснэгтэд тоймлон харуулав. Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөний бодит шинж чанарыг дээшлүүлэх зорилгоор туршилтын төслүүдийг хэрэгжүүлсэн бөгөөд тэдгээрийн талаар дараагийн бүлэгт өгүүлэх болно.

Хүснэгт 3.4.1 Хөдөөгийн мал аж ахуйг сайжруулах төлөвлөгөөний бүтэц

Бодлого / Эцсийн үр дүн	Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөл
Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоо сайжирах (Зудын хохирлыг багасгах, бэлчээрийн талхдалыг арилгах)	Бэлчээрийн ашиглалт, худаг байгуулалт, менежмент	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн төсөл Бэлчээр ашиглалт, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө "Өвөлжөө хаваржааны орчинг тохижуулуулах" "Ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг зээмших" Худаг байгуулалтыг сайжруулах төлөвлөгөө "Зуслан (отрын нутаг)-гийн уст цэгийн тоог нэмэгдүүлэх" "Өвөлжөө, хаваржааны ойр орчмын усжуулалтын үр ашгийг дээшлүүлэх" Худгийн хамгаалалт, засвар үйлчилгээний төлөвлөгөө "Шинээр гаргасан ба сэргээн засварласан худгийн засвар үйлчилгээг тогтворжуулах"
	Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах	Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах төсөл "Мал эмнэлгийн үйлчилгээг сэргээх, сайжруулах"
		Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх төсөл "Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлгийн ажлыг урагшлуулах"
		Мал маллагааны арга, технологийг сайжруулах төсөл "Мал маллагааны арга, технологийг сайжруулан дээшлүүлэх"
		Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх төсөл "Менежментийн чадварыг бий болгох, бэхжүүлэх"
	Малчин өрхийн орлогыг тогтворжуулах	Мал аж ахуй эрхлэлтийн менежментийг сайжруулах төсөл "Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх ба жижиг бизнесийг хөгжүүлэх"
		Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах төсөл "Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийн дэд бүтцийг бий болгох"
Хүний нөөцийг хөгжүүлэх		

3.5 Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тэргүүлэх дараалал

“Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн бүрэлдэхүүн хэсэг”-ийг хөгжлийн 4 бүрэлдэхүүн хэсгүүдийн дотроос нэн тэргүүнд авч үзвэл зохино. Бэлчээрийн зүй зохистой ашиглалт, худаг байгуулалтын асуудал нь бүс нутгийн нүүдлийн мал аж ахуйн оршин тогтнох суурь дэвсгэр төдийгүй мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой явуулах хамгийн чухал урьдчилсан нөхцөл мөн. Тэрчлэн “Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах” бүрэлдэхүүн хэсэг нь тогтвортой өсөлтөд хувь нэмэр оруулаад зогсохгүй мал аж ахуйн салбарыг бүхэлд нь урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх нөхцөлийг хангахад чухал ач хобогдолтой юм. Харин “Малчин өрхийн орлогыг тогтворжуулах” бүрэлдэхүүн хэсэг нь ихээхэн хэмжээний үр нөлөөлөл үзүүлэх найдлагыг төрүүлж байгаа боловч мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдал, түүхий эдийн ханган нийлүүлэлтээс шууд хамаарах тул харьцангуй туслах чанарын бүрэлдүүн хэсэг юм. Хөгжлийн 4 бүрэлдэхүүн хэсгийн хоорондын уялдаа холбоог дараахь зурагт харуулав.



Зураг 3.5.1 Хөгжлийн 4 бүрэлдэхүүн хэсгийн уялдаа холбоо, ач холбогдлын дараалал

БҮЛЭГ 4 Туршилтын төслийн судалгаа

Бүлэг 4 Туршилтын төслийн судалгаа

4.1 Туршилтын төслийн судалгааны зорилго

Туршилтын төслийн судалгааны зорилго нь төслийн хүрээнд зохион байгуулагдах малчдын бүлгийн хэрэгжүүлэх ажлын үр ашгийг тодруулахад оршино.

Бэлчээрийн менежмент, худгийн ашиглалт, засвар үйлчилгээний асуудлыг малчдын бүлгийг зохион байгуулж, хариуцуулах замаар шийдвэрлэх нь зүйтэй юм. Иймд туршилтын төслийн явцад малчдын бүлгийг байгуулах ажлын эхний алхам болох худгийн ашиглалт, засвар үйлчилгээний тогтолцоог бий болгох явдал нь гол зорилт байлаа. Туршилтын төслийн үйл ажиллагаа нь дээрх зорилтыг биелүүлэхэд шаардлагатай процедурыг бий болгож, уг төслийг хэрэгжүүлж дууссаны дараа Монголын Засгийн газар малчдын бүлгийн зохион байгуулалт, худаг гаргах ажлыг дэмжих арга зам ямар байж болохыг судлахад чиглэгдсэн болно. Туршилтын төслийн агуулга нь худгийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах малчдын бүлгийг зохион байгуулах, түүнээс гадна мал аж ахуйг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулах, түүнд хамрагдах малчдын бүлгийг зохион байгуулахад оршино.

Малчид өөрсдөө бие даан удирдах малчдын бүлгийг үүсгэн байгуулж, худгийн менежмент болон бусад хамтарсан үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд идэвх санаачилга, хүчин чармайлт гарган ажиллах нь амжилтанд хүрэх гол нөхцөл болох бөгөөд нөгөө талаар тэдний үйл ажиллагааг нэгэн гольдролд нэгтгэн, зохион байгуултанд оруулах явцыг зүй зохистой дэмжих засаг захиргааны дэмжлэгийн тогтолцоо зайлшгүй шаардагдах юм. Иймд малчдын бүлгийг зохион байгуулах, өөрийгөө удирдах эрх мэдлийг нь хэрэгжүүлэхэд чиглэсэн туршилт судалгааны ажлыг явуулахын хамт, засаг захиргааны дэмжлэгийн тогтолцоог бий болгож, чадавхийг нь дээшлүүлэхтэй холбоотой асуудлыг ч анхааран судалж үзсэн болно.

4.2 Нарийвчилсан төлөвлөгөөнд хамрагдсан бүс нутгийн сонголт

Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын дундаас нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах аймгаар Дорноговь аймгийг сонгож авсан. Сонгох үйл ажиллагаа дараах байдлаар явагдсан болно.

(1) Судалгаанд хамрагдах аймгийг сонгоход голчлон анхаарсан зүйл

Судалгааны баг болон орон нутгийн засаг захиргааны байгууллага хамтран судалгаанд хамрагдах нутаг дэвсгэрийн хүрээг тогтоож, түүнд оролцох малчдыг элсүүлэн, улмаар тэднийг зохион байгуулалтад оруулсны үндсэн дээр туршилтын төслийг хэрэгжүүлнэ. Иймд туршилтын төсөлд хамруулах бүс нутгаас нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах аймгийг сонгохдоо дараахь зүйлийг харгалзан үзсэн болно.

- Туршилтын судалгааны хувьд богино хугацаанд нүдэнд харагдахуйц үр дүнг гаргах явдал хамгийн чухал.
- Туршилтын төслийн үр дүнг говь-хээрийн аймгуудад тохируулан ашиглах боломжтой байх ёстой тул байгаль орчны нөхцлийн хувьд говь нутгийн онцлог шинж ба тухайн бүс нутгийн нийтлэг шинж чанарыг агуулсан аймгийг сонгох нь зүйтэй.
- Төслийн хэрэгжих хугацаанд судалгааны ажлын тодорхой үр дүнг гаргах шаардлагатай тул хэдий говийн бүсийн хатуу ширүүн нөхцөл дунд ч гэсэн судалгааны ажил гүйцэтгэхэд тохиромжтой орчин зайлшгүй шаардлагатай.
- Бусад төслүүдийн хэрэгжилтийн тэгш байдлыг хангах үүднээс тодорхой нутагт ижил төрлийн олон төсөл төлөвлөх нь тохиромжгүй.

(2) Сонголт хийх шалгуур үзүүлэлтүүд ба үнэлгээний үр дүн

Бэлчээрийн даац хэтрэлт нь тухайн нутаг тус бүрээр авч үзвэл аль ч аймагт байдаг асуудал юм. Бэлчээрийн даац, ашиглалтын хувь хэмжээгээр нь аваад үзэх юм бол ихэнх сумдад нь ургамалжилт болон малын тоо толгойн тэнцвэр алдагдаж, бэлчээрийг даац хэтрүүлэн ашиглаж буй аймгуудад (Дундговь, Өмнөговь) "малын тоо толгойг хэрхэн цөөрүүлэх вэ?", "бэлчээрийг хэрхэн амраах вэ?" гэсэн асуудлууд шийдвэрлэх зорилт болон тавигдаж байгаа боловч зудын эсрэг авах арга хэмжээний хувьд өрөөсгөл шинжтэй байж болзошгүй юм.

Газар доорх усны нөөцөөр нь аваад үзвэл бага гүний усны хувьд Өмнөговьд булаг шанд элбэг бүлгүүд ерөнхийдөө Өмнөговь, Дорноговь, Дундговь гэсэн дарааллаар багасаж, гүний усны хувьд Дорноговь, Өмнөговь, Дундговь гэсэн дарааллаар нөхцөл нь таагүй болж ирж байна. Газар доорх усыг ашиглах боломжийн хувьд Дорноговь, Өмнөговь аймгууд тодорхой боломжийн хүрээнд байгаа боловч Дундговь аймгийн хувьд энэ тал дээр бэрхшээлтэй байж болзошгүй.

Нэг худагт ногдох бэлчээрийн талбай нь Дорноговьд 53km^2 , Өмнөговьд 43km^2 , Дундговь аймагт 25km^2 байгаа нь Дорноговь аймгийн үзүүлэлт Дундговь аймгийнхаас 2 дахин их байна гэсэн үг юм. Дорноговь аймгийн нийт худгийн дотор сэргээн засварлах боломжтой худгийн эзлэх хувь 46%, Өмнөговь аймагт 28%, Дундговь аймагт 13% байгаа нь Дорноговь аймагт сэргээн засварлаад ашиглаж болох худаг олонтой болохыг харуулж байна.

Зудын хохирол, ядуурлын асуудал нь говийн бүс нутагт нийтлэг том асуудал тул эдгээр үзүүлэлтүүдийн ялимгүй зөрөө ялгаагаар нь судалгаанд хамрагдах аймгийг сонговол нутгийн оршин суугчдын дургүйцлийг төрүүлж болзошгүй юм.

Иймд төр, захиргааны байгууллагууд, судалгаанд хамрагдах нутгуудын эрх тэгш байдлыг хангаж, сонголтын шалтгааныг ил тод тайлбарлан ойлгуулах, судалгааны ажлыг оновчтой, үр ашигтай хэрэгжүүлж, үр дүнг нь бүс нутгийн хэмжээнд үр дүнтэйгээр өргөжүүлэн дэлгэрүүлэх нөхцөлийг бий болгох явдал маш чухал юм. Туршилтын судалгааны төсөл нь тухайн газар нутагт удаан хугацаагаар хэрэгждэг төслүүдээс

ялгаатай байдаг. Туршилтын төслийн талбар нь энд тэнд таруу байрласан байдаг бөгөөд судалгааны явцад туршилтын төслийн объект, аймгийн ЗДТГ, ХХАА яамны хооронд судалгаа, дүн шинжилгээ хийх, тайлан боловсруулах, холбогдох байгууллагуудтай уулзах, хурал цуглаан зохион байгуулах ажлаар байнга явж байх шаардлага гарна. Ийм ч учраас хатуу ширүүн говийн нөхцөлд явуулах судалгааны ажилд таатай орчин бүрдүүлэх явдал нэн чухал юм.

Дээрх нөхцөл байдлыг судлан үзсэний үр дүнд нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах аймгаар Дорноговь аймгийг сонгон авсан.

(3) Дорноговь аймгийн онцлог

Дорноговь аймаг 2002 онд аймгийн “Бүсчилсэн Хөгжлийн Бодлого”, “Аймгийн XXI Зууны Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлж байгаа ба сумууд өөрсдийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх бодлогыг дээрх хөтөлбөрүүдтэй уялдуулан төлөвлөснөөс гадна сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгасан сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх зорилт тавьж байна.

Нийт сумдын эдийн засгийн үндсэн гол салбар нь мал аж ахуй бөгөөд Айраг, Даланжаргалан, Иххэт сумдад уул уурхайн үйлдвэрлэл чухал ач холбогдолтой юм. Алтанширээ, Сайхандулаан, Хатанбулаг, Мандах, Улаанбадрах, Эрдэнэ зэрэг бусад сумдад ашигт малтмалын хайгуулын ажил хийгдэж байна.



Зураг 4.2.1 Дорноговь аймгийн хүн ам ба үйлдвэрлэл төвлөрсөн бүс нутгууд ба хөдөө аж ахуйн бүс нутаг

Нутаг дэвсгэртээ ашигт малтмалын нөөц бүхий сумд, ялангуяа жонш, нүүрс, алт зэрэг ашигт малтмалуудын нөөц, илэрц бүхий сумдууд уул уурхайн үйлдвэрлэлд түшиглэн нийгэм эдийн засгаа хөгжүүлэх бодлого барьж байхад Алтанширээ, Хөвсгөл, Хатанбулаг, Дэлгэрэх, Мандах зэрэг сумууд мал аж ахуйн үйлдвэрлэлийг үндсэн чиглэлээ болгож ойрын ирээдүйд сумын хэмжээнд ашигт малтмалын хайгуул хийлгэн нөөц тогтоолгосны үндсэн дээр уул уурхайн үйлдвэрлэлийг сумын хөгжлийн нэг тулгуур болгон хөгжүүлэхээр зорьж байна.

Замын-Үүд суманд цаашдаа эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдах бөгөөд тус сум одооноос уг ажлын үр шимийг хүртэж эхэлж байна. Дээр нь түүнийг дагаж Замын-үүд, Хатанбулаг сумдын хилийн боомт газруудад тэдгээрийг түшиглэн ойр орчмын бүс нутгийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжин хөгжсөнөөр илүү нэмүү өртөгтөй мал аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах таатай боломж нээгдэж байна.

Хилийн боомтод ойр орших сумдын адил төмөр зам дагуу орших Айраг, Далаанжаргалан, Сайншанд, Өргөн болон Эрдэнэ зэрэг сумдад мал аж ахуйн бус салбарын эдийн засгийн үйл ажиллагааны ач холбогдол нэмэгдэж, эдийн засгийн хөгжлийн өргөн боломж нээгдэж байна. Эдгээр сумдад мал аж ахуйн бус салбар дахь ажлын байр нэмэгдэж, хотжилт, суурьшилт явагдаж байна. Нөгөө талаар алслагдсан сумдаас олон хүн төв суурин газар руу шилжих хандлага гарч байна. Эдгээр хандлагуудаас дүгнэвэл алслагдсан сумдад гол салбар нь мал аж ахуй хэвээр үлдэж байгаа бол хүн ам төвлөрсөн газруудад мах болон цагаан идээний эрчимжсэн үйлдвэрлэл, аль эсвэл улам үйлдвэржүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх эрэлт хэрэгцээ ихсэж байгаа юм.

Ядуу өрхүүд ба эмзэг бүлгийнхэн ажил эрхлэх боломж болон амьжиргааны бусад замыг сонгохын тулд хот суурин руу шилжиж байхад чинээлэг малчдын зарим хэсэг шим тэжээл сайтай бэлчээр хайж хүн ам олонтой газраас холдон нүүх явдал байна.

4.3 Туршилтын төсөл хэрэгжүүлэх сумдын сонголт

Энэхүү сонголтын хувьд Дорноговь аймгийн дундаж нийтлэг шинжийг агуулсан сумыг сонгох нь зүйтэй гэж үзэж байсан боловч төсөл нь нэг талаар зудын хохирлыг арилгах яаралтай арга хэмжээнд хувь нэмэр оруулах зорилгыг агуулж байгаа бөгөөд төслийн хүрээнд багахан цар хүрээтэй хэдий ч тодорхой хэмжээний барилгын ажлуудыг хийх тул сумдын "зудын хохирлын хэмжээ" дээрх сонголтын чухал шалгуур үзүүлэлт болсон юм.

Дараахь хүснэгтэд аймгийн нийт 14 сумын 1996 оноос хойшхи малын тоо толгойн өөрчлөлтийг үзүүлэв.

Хүснэгт 4.3.1 Дорноговь аймгийн малын тоо толгойн өөрчлөлт

	Мальн тоо							Мальн тоо өөрчлөлт (1996 он = 100)							Мальн тоо толгойн харьцаа (Эудтай жилүүд Хамгийн олон малтай жил)
	1996	1997	1998	1999	2000	2001	2002	1996	1997	1998	1999	2000	2001	2002	
Айраг	65,891	58,993	63,825	68,959	73,615	62,760	67,928	100.0	89.5	104.7	111.7	95.2	103.1	85.3	
Алтанширээ	53,368	56,455	62,355	69,348	73,770	52,419	55,023	100.0	105.8	116.8	129.9	138.2	98.2	103.1	
Далайнаралант	80,427	79,313	88,782	94,834	98,901	66,407	69,156	100.0	98.6	110.4	117.9	123.0	82.8	86.0	
Дэлгэрэх	78,500	73,010	84,274	97,777	94,733	67,137	71,141	100.0	93.0	107.4	124.8	120.7	83.5	90.6	
Увсат	57,125	58,037	64,530	67,069	67,173	59,689	57,412	100.0	101.5	112.9	117.3	117.5	104.4	100.4	
Мандах	65,122	70,123	68,684	80,442	69,870	64,483	71,015	100.0	107.7	105.5	123.5	107.3	99.0	109.0	
Өргөн	63,087	66,723	71,711	80,707	85,292	67,049	67,494	100.0	105.8	113.7	127.9	135.2	106.3	107.0	
Сайншандуулан	54,157	56,889	57,572	65,038	63,321	66,043	65,615	100.0	105.0	106.3	120.1	116.9	121.9	121.2	
Улаанбадрах	81,681	88,628	92,442	96,881	84,990	68,015	55,846	100.0	108.5	113.2	118.6	104.1	83.3	68.4	
Хатанбулаг	125,016	137,116	141,052	139,846	102,175	80,013	86,924	100.0	109.7	112.8	111.9	81.7	64.0	69.5	
Хөвсгөл	72,475	79,369	80,843	88,008	67,980	48,025	46,727	100.0	109.5	111.5	121.4	93.8	68.3	64.5	
Эрдэнэ	68,855	76,272	80,141	87,006	80,283	71,138	52,506	100.0	110.8	116.4	126.4	116.6	103.3	76.3	
Сайншанд	48,503	54,374	51,897	62,848	64,110	56,979	53,623	100.0	112.1	107.0	129.6	132.2	117.5	114.7	
Замын Үүд	8,312	7,881	9,751	11,448	10,378	8,104	3,361	100.0	94.8	117.3	137.7	124.9	97.5	40.4	
Нийт	922,569	963,183	1,017,859	1,110,231	1,006,591	838,261	825,771	100.0	104.4	110.3	120.3	112.4	90.9	89.5	74.4

*Тодсоор харуулсан газар : Мальн өсөлтийн оргил жил

Эх сурвалж: Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар

Дорноговь аймгийн урд хэсгийн Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумд зудад байнга өртдөг, хохирлын хэмжээ их байдгаас нэн тэргүүний ээлжинд төсөл хэрэгжүүлэх шаардлагатайгаас гадна Хүнс, Хөдөө аж ахуйн яамнаас бага гүний уст цэг тогтоох хайгуул судалгааны ажил тэдгээр сумдад хамгийн түрүүнд хийгдсэн байсан зэргийг харгалзан үзэж эдгээр 4 сумаас туршилтын төслийг хэрэгжүүлэх газрыг сонгох чиглэл баримталсан болно. Эдгээрээс Хатанбулаг сум Сайншанд хотоос 230 км-ийн зайтай, энэ зайг туулахад хоёр талдаа ойролцоогоор 8 цаг зарцуулагдах тул судалгааг үр бүтээмжтэй байлгах үүднээс хассан.

Судалгааг, төслийн үр шимийг хүртэгч этгээдийг оролцуулах хэлбэрээр хэрэгжүүлэх үндсэн дээр туршилтын төсөлд хамрагдах 3 суманд Төслийн Үе шатны Менежмент буюу PCM (Project Cycle Management)-ийг ашигласан семинар сургалтыг явуулан малчдын өөрсдийнх нь боловсруулсан төслийн саналыг хүлээн авахаар төлөвлөсөн байлаа. Иймд 3 сумаас гарч ирэх төслийн саналуудыг судалж үзэх, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог нягтлахад ихээхэн хугацаа шаардагдаж, төлөвлөсөн хугацаандаа уг ажлыг дуусгахад хүндрэлтэй болох магадлалтай байв. Ийм нөхцөл байдлын дунд Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сумдыг туршилтын төсөл хэрэгжүүлэх бүс нутгаар сонгон авсан юм.

4.4 Туршилтын төслийг хэрэгжүүлэх арга зам


4.4.1 Гишүүдийн бүрэн оролцоог хангах хэлбэрийн төлөвлөлт

Туршилтын судалгааны хэрэгжилтийн явцад төслийг хэрэгжүүлэгч ба түүний үр шимийг хүртэгч болох малчдын санаа бодлыг нэн тэргүүний ээлжинд харгалзан үзнэ. Энэ нь малчид өөрсдөө бүлгээ байгуулж, үүний үндсэн дээр төслийн саналыг гаргаж ирэх байдлаар бүх үйл явцад нь гишүүд бүрэн оролцох хэлбэрийн төслийн санал боловсруулах аргыг хэрэглэн, туршилтын төслийн хэрэгжилтэд эзэн хүний ёсоор хандах сэтгэл зүйг нь өндөржүүлж, улмаар өндөр үр бүтээлтэй, тогтвортой төслийг хэрэгжүүлэн удирдах бүтцийг бий болгох зорилтоос урган гарч байна.

4.4.2 Туршилтын төслийг хэрэгжүүлэх дараалал

(1) Хэрэгжүүлэх дараалал

Туршилтын төсөл нь малчид болон иргэдийн өөрсдөө боловсруулсан төслөөс төрийн захиргааны байгууллага (сумын ЗДТГ) ба судалгааны баг сонгон шалгаруулах гэсэн процессоор эхэлнэ. Үүний тулд юуны өмнө уг бүлэгт өөрсдийн нь нөхцөл байдлыг ойлгон ухамсарлуулах зорилгоор төслийн үе шатны менежментийг сургалт (PCM Workshop)-ыг зохион байгуулна. Дараа нь сургалтаар гарч ирсэн асуудалд хийсэн дүн шинжилгээнд үндэслэсэн төслийн саналыг бүх бүлгүүд боловсруулж, судалгааны баг ба сумын ЗДТГ-аар шалгуулан, эндээс туршилтаар хэрэгжлэх төслүүд шалгарч, хэрэгжилтэндээ орно. Туршилтын төслийн хэрэгжилт хүртэлх үйл явцыг 4.4.1 дүгээр зурагт үзүүлэв (нарийвчилсан дэс дараалал, тайланг Хавсралт F-ээс үзнэ үү).



Зураг 4.4.1 Туршилтын төслийн хэрэгжилт хүртэлх үйл явц

(2) Сургалт явуулсан тухай болон уг сургалтаар дамжин хэрэгжсэн зохион байгуулалтын тухайд

Сургалтыг "Төслийн Үе шатны менежментийн сургалт (PCM Workshop)" ба "Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалт (PO Workshop)" гэсэн 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Төсөл эхэлснээс хойш үнэлгээ, мониторингийн сургалтыг зохион байгуулж явуулсан болно.

Эдгээр сургалтууд нь малчид ба иргэдэд харилцан ярилцаж, санаа бодлоо нэгтгэх боломжийг давхар олгодог. Мөн "Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалт"-аар бүлгийн дотоод журам, үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарийг тодруулан өгснөөр зохион байгуулалттай удирдлагын үйл ажиллагаа явуулах бэлтгэл болж өгсөн юм.

1) Төслийн үе шатны менежментийн сургалт (PCM Workshop)

Төслийн үе шатны менежментийн сургалтыг, сумын ЗДТГ дээр ЗДТГ-ын ажилтнууд, иргэд, малчдыг байлцуулан зохион байгуулсан. Юуны өмнө, туршилтын төслийн бүтэц зохион байгуулалт, түүнд хамааралтай хүмүүсийн талаарх дүн шинжилгээ, асуудлын дүн шинжилгээ, зорилгын талаарх дүн шинжилгээ, төсөлд юугаар хэрхэн оролцохоо яаж сонгох, туршилтын төслийн саналыг хэрхэн боловсруулах талаар тайлбарлаж танилцуулсан болно.

2) Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалт (PO Workshop)

Төслийн санал нь шалгарсан бүх бүлгүүд дээр "Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалт"-ыг зохион байгуулж, эдгээр бүлгүүд туршилтын төслийнхөө үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг өөрсдөө боловсруулсан. Малчдын бүлгүүдийн хувьд сургалтыг үйл ажиллагаа явуулах газар дээр нь буюу малчны гэрт нь зохион байгуулсан бол сумын иргэдийн бүлгүүдийн хувьд сумын ЗДТГ-ын байрыг ашиглан зохион байгуулсан. Төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа ба бусад бүх үйл ажиллагаанаас хүлээгдэх үр дүн, зорилт, хэрэгжүүлэх хугацаа, хариуцагчид болон хэрэгжүүлэгчид, зардал хариуцагчид, төсөл хэрэгжүүлэх явцад харгалзан үзэх ёстой асуудлуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж өгсөн болно. Ийнхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг хүснэгтээр гаргаснаар төсөлд хамрагдагсад уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлсийн талаар хэлэлцэн, бүлэг дотроо мэдээллийг хамтран эзэмших ба ашиг орлого, зардалтай холбоотой асуудлуудын талаар шийдвэр гаргах тал дээр санаа оноогоо нийлүүлж чадсан.

"Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалт"-ыг явуулахад бүлгийн зохион байгуулалтыг бэхжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үүднээс доорх асуудлуудыг анхааралдаа авч зохион байгуулсан болно. Үүнд:

- Туршилтын судалгааны зорилгоос хазайхгүй хэмжээнд, малчид зардлыг нь хариуцаад ч болсон хиймээр байна гэж хүсэхүйц ажлын агуулгыг уг малчдаар өөрсдөөр нь гаргуулахыг зорих.
- Зардал хариуцах тухай ойлголтыг малчдад бүрэн ойлгуулах.
- Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцох оролцоо, хичээл зүтгэлийг дэмжих тогтолцоог бий болгох.
- Үйл ажиллагаанд оролцоход нь хөшүүрэг, боломж нөхцөл гаргаж өгч байхыг анхаарах.

- Тухайн орон нутгийн засаг захиргааны чадавхийг дээшлүүлэх тал дээр ч давхар анхаарч, үүнийг үйл ажиллагааныхаа цар хүрээнд оруулах.

3) Үнэлгээ, мониторингийн сургалт

Туршилтын судалгааг, түүний хэрэгжих магадлал, үр ашигтай байдал зэргийг судлахын хамтаар уг судалгааг хэрэгжүүлэх явцад хуримтлуулсан туршлагыг дараагийн төлөвлөгөөндөө тусгаж, илүү бодит төлөвлөгөө боловсруулахын тулд хэрэгжүүлдэг. Үүний тулд тогтмол хугацаанд мониторинг (үргэлжилсэн ажиглалт) хийж, "Хэрэгжилтийн явцыг магадлан бүрэн дүүрэн ойлголт авах" буюу төслийн хэрэгжилтэд саад болж байгаа асуудлыг цаг алдалгүй илрүүлэн түүн дээрээ тулгуурлан "Чиг шугамаа" тодотгож явах шаардлагатай юм. Тэрчлэн мониторингийн дүгнэлт дээр үндэслэн туршилтын судалгааны явцад гарч буй өөрчлөлтийн талаар бүрэн дүүрэн ойлголт авах, өөрөөр хэлбэл төслийн хэрэгжилт хүлээсэн үр дүнд хүрч байна уу үгүй юу гэдгийг мэдэж, "Зөвлөмж (туршилтын судалгааг цаашид ямар байдлаар хэрэгжүүлэх талаарх санал, зөвлөмж)" болон "Зааварчилга (хэрэгжилтийн явцад болон цаашид хэрэгжүүлэх боломжтой ижил төрлийн төсөлд санамж, гарын авлага болох зүйлүүд)" боловсруулахын тулд үнэлгээ хийж явдаг. Энэ зорилгоор "Үнэлгээ, мониторингийн сургалт"-ыг зохион байгуулсан.

Туршилтын судалгаа хэрэгжих явцад төслийн дунд шатны үнэлгээг 2 удаа, төсөл хэрэгжиж дуусах үед төгсгөл шатны үнэлгээг 1 удаа, нийт 3 удаагийн үнэлгээ хийлээ. Үнэлгээний аргын хувьд малчдын өмч эзэмших чадварыг дээшлүүлж, үйл ажиллагааныхаа байдлыг бүрэн мэдэж хянах байдлыг нь сайжруулахын тулд төслийн үр шимийг хүртэгч, хэрэгжүүлэгч болох тэдгээр малчдаар өөрсдөөр нь "Идэвхтэй оролцох хэлбэр"-ийн үнэлгээг зохион явуулсан. Бүлгүүд өөрсдөө боловсруулсан хүснэгт хэлбэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө үндэслэн, өөрсдийн үйл ажиллагааг өөрсдөө үнэлж, үйл ажиллагааны зүйл тус бүрээр түүний биелэлт, олсон амжилт, үнэлгээ, тулгарсан асуудлууд, авсан арга хэмжээ болон цаашид авах арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, хариуцагч зэргийг үнэлгээний хүснэгтдээ тодорхойлон бичиж явсан.

(3) Төслийн саналын сонгон шалгаруулалт

Малчид, иргэдээс ирүүлсэн төслийн саналуудаас хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулсан. Сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтүүдийг 4.4.1 дүгээр хүснэгтэд үзүүлэв. Эдгээр шалгуураас гадна судалгааны багаас газар дээр нь очиж бодит байдлыг ажиглах, уг малчдын бүлгийн өнөөг хүртэл явуулж ирсэн үйл ажиллагааны талаарх асуулга судалгааг давхар явуулсан. Мөн зөвхөн малчдын санал хүсэлтээр хязгаарлагдалгүй мал аж ахуйн ирээдүйн хөгжлийн шаардлагын улмаас сумын засаг захиргаатай зөвлөлдсөний үндсэн дээр туршилтын төслүүдийг сонгон шалгаруулсан болно.

Хүснэгт 4.4.1 Төслийн саналуудыг сонгох шалгуур

Төслийн саналыг сонгох шалгуур	Шийдвэр гаргах үндэслэл
1. Бүлгийн чадварлаг ахлагчтай байх	Бүлгийн бүрэлдэхүүн ба өнөө хүртэл явуулж ирсэн үйл ажиллагаа - Бүлгийн үйл ажиллагаа удаан хугацаанд явагдаж байгаа. - Ноолуур борлуулах зэрэг мөнгөтэй холбоотой үйл ажиллагааг хамтран явуулж буй. - Төрөл садны хүмүүсээс бусад хүмүүсийн эзлэх хувь хэр байгаа зэрэг болно
2. Бүлгийн гишүүд төсөлд оролцох чин хүсэл, эрмэлзлэлтэй байх	Бүлэг үнэхээр байгуулагдсан байгаа эсэхийг магадлах - Бүлгийн үйл ажиллагаа эхлээд удаж байгаа - Бүлгийн үйл ажиллагаа олон талтай эсэх
3. Зардлаа хариуцах талаар ойлголттой байх	Төслийн саналд дурьдагдсан зардал хариуцах тухай ойлголт болон тэр нь хэрэгжих бодитой хэмжээнд байгаа эсэхийг лавлах
4. Төслийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудын биелэх боломж	Тавьсан зорилгын биелэлт болон төслийн агуулгын уялдаа холбоог онолын хувьд лавлах
5. Малчдын орлого нэмэгдэж, амьдрал нь сайжрахад оруулах хувь нэмэр	Техникийн дүгнэлт хийх
6. Төсөл дууссаны дараа үр дүн нь тогтвортой хадгалагдах (Жишээ нь: Бэлчээр ба худгийн ашиглалтын тэнцвэрийг хадгалж байх)	Технологийн дүгнэлт хийх. Төслийн агуулгыг засварласны үндсэн дээр хүлээж авч болохоор санал бол малчны бүлэгтэй зөвлөлдөнө.
7. Орлого, зарлагын тэнцвэр	Хэдий хэмжээний зардал шаардагдахыг дүгнэх
8. Судалгааны ажлын хугацаанд мониторинг ба үнэлгээ хийх боломжтой эсэх	Үр дүн нь туршилт ын судалгааны хугацаанд тодорхой үзүүлэлтээр илрэх боломжтой эсэхэд нь дүгнэлт хийх
9. Төсөл хэрэгжих газарт очих боломж	Туршилтын судалгаа учир олон түмэнд загвар болохуйц үр дүн гаргах талаас нь бодож харилцаа, холбооны хувьд тохиромжтой газар төвлөрүүлэн хэрэгжүүлэх
10. Сум ба аймгийн санал, бодол	Сум, аймагтай зөвлөлдөх

4.5. Шалгарсан төслүүд ба хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төслийн хамрах хүрээний хоорондын хамаарал

Гарч ирсэн төслийн саналуудыг хянаж үзсэний дүнд дараах төслүүдийг шалгаруулсан.

Хүснэгт 4.5.1 Шалгарсан туршилтын төслүүд ба тэдгээрийн дэвшүүлсэн зорилтууд

Туршилтын төслүүдийн нэр	Хэрэгжүүлэх сумд	Хэрэгжүүлэгчид	Дэвшүүлсэн зорилт
Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөл	3 сум*	Малчдын бүлгүүд	Бэлчээрийн талхдалыг багасгах
Малжуулах сангийн төсөл	Эрдэнэ	Эрдэнэ сумын ЗДТГ	Сумын ЗДТГ "Малжуулах сан"-тай болно.
Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах төсөл	Эрдэнэ	Эрдэнэ сумын ЗДТГ	Бүрдэнийн сувиллын газрын менежментийг сайжруулах
Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах төсөл	Эрдэнэ	Малчдын бүлэг	Сүү, сүүн бүтээгдэхүүнийг жил тойрон борлуулах тогтолцоотой болох
Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах төсөл	3 сум	Иргэдийн бүлэг	Хөнгөлөлттэй хөрөнгө оруулалтын үр дүнд суман дээр боловсруулах жижиг үйлдвэр (хонины ноосны) байгуулагдана.
"Гар худгийн кампанит" төсөл	3 сум	3 сумын ЗДТГ-ууд	Сумын захиргаа гар худгийн тоог олшруулах ажлыг дэмжих чадвартай болно.

* Тайлбар: 3 сум гэдэг нь Дорноговь аймгийн Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сумд болно.

Тус төслийн эцсийн үр дүн (зорилт) нь “Зудын хохирлыг багасгах, бэлчээрийн талхдалыг арилгах”-ад чиглэсэн “Хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах” явдал бөгөөд түүний хүрээнд хэрэгжсэн жижиг төслүүд тус бүр дээрх зорилтын аль бүтэц бүрэлдэхүүн хэсэгт хамаарч буйг дараахь хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4.5.2 Туршилтын төслүүд ба хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоо

Бодлого чиглэл, эцсийн үр дүн	Хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг	Төсөл	Тухайн бүрэлдэхүүн хэсэгт тохирох туршилтын төсөл	
Хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах (Зудын хохирлыг багасгах, бэлчээрийн талхлагдлыг арилгах)	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежмент	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөл ба гар худгийн кампанит ажил өрнүүлэх төсөл	
	МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг сайжруулах	Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах		
		Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх	Малжуулах сан	
		Мал маллагааны арга, технологийг сайжруулах	Малжуулах сан	
		Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх	Малжуулах сан	
	Малчин өрхийн орлогыг тогтворжуулах	МАА-н эрхлэлтийн менежментийг сайжруулах МАА-н бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах	Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах, хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах, Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах төсөл	
Хүний нөөцийг хөгжүүлэх	-	Туршилтын төслүүдээр дамжуулан хүний нөөцийг сургаж бэлтгэх		

Мал эмнэлгийн үйлчилгээ сайжруулах төслийн хувьд мэргэжлийн чанартай асуудал давамгайл, малчид болон иргэд өөрсдөө голлон хэрэгжүүлж ажиллахад бэрхшээлтэй талтайгаас төслийн санал гарч ирээгүй. Мөн, Германы техникийн хамтын ажиллагааны байгууллага (GTZ)-аас дэмжин хэрэгжүүлж буй “Мал эмнэлгийн үйлчилгээний хувьчлалыг дэмжих төсөл” (Support to the Privatization of Veterinary Services) Дорноговь аймагт хэрэгжиж байгаа тул тус судалгааны ажилтай давхардуулахгүйн тулд туршилтын төсөл хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн болно.

Туршилтын төслүүдийн нэг болох “Малжуулах сангийн төсөл”-ийн хувьд, ихээхэн чухал төслүүд болох “Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх төсөл”, “Мал маллагааны арга, технологийг сайжруулах төсөл”, “Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх төсөл”-үүдээс элементүүдийг нь гарган ирж, туршилтын төсөл болгон төлөвлөсөн.

“МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг сайжруулах” болон “Малчин өрхийн орлогыг тогтворжуулах” гэсэн хэсгүүдийн хувьд туршилтын төслөөр хэсэгчилсэн байдлаар тус тусад нь хэрэгжүүлж буй төдий тул үр дүнг нь (нарийвчилсан) төлөвлөгөөнд тусгахад (feedback) учир дутагдалтай.

Нөгөө талаас “Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн” хэсэг нь хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төлөвлөгөөний чухал хэсэг тул бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөл ба гар худгийн кампанит ажил өрнүүлэх төсөл гэсэн туршилтын судалгаагаар дараагийн төлөвлөгөөнд тусгах асуудлыг нарийвчлан авч үзэж, нарийн тодорхой төлөвлөгөө боловсруулан гаргаж ирэх боломжтой болсон болно.

4.6 Туршилтын төслийн хэрэгжилтийн агуулга

4.6.1 Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн төсөл

(1) Зорилго ба үндсэн чиглэл


Бэлчээрт байгуулсан худгийг зүй зохистой ашиглан хамгаалснаар бэлчээрийг тогвортой үргэлжлүүлэн ашиглах боломжтой болно. Бэлчээрийг тогвортой үргэлжлүүлэн ашигласнаар, түүний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн бэлчээр ашиглалтын үйл ажиллагаа хэрэгжиж, тодорхой нэгэн газарт үүссэн хүн, малын хэт төвлөрлийг арилгаж болно.

Иймд бэлчээр ашиглалтын явцад үүссэн хэт төвлөрлийн улмаас бий болсон бэлчээрийн талхлагдлыг арилгах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлсэн болно. Төсөл нь доор дурдсан үндсэн үйл ажиллагаагаар дамжуулан малчдын бүлэгт худгийнхаа ашиглалт, засвар үйлчилгээг өөрсдөө хариуцаж, бэлчээрийг зүй зохистой ашиглах чадварыг төлөвшүүлэхэд чиглэсэн. Үүнд:

- Худаг, түүний ойр орчмын бэлчээрийг ашиглах малчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулах
- Шинээр худаг гаргах, сэргээн засварлах
- Бэлчээр ашиглалтын журмыг, уг бэлчээрийг ашигладаг малчдын бүлэг өөрсдөө боловсруулах

(2) Төслийн бүтэц, зохион байгуулалт

Төслийн бүтэц, зохион байгуулалтыг дараах зурагт үзүүлэв. Төслийн хүрээнд сэргээн засварлагдсан худгууд, тэдгээр худгуудыг ашиглах малчдын бүлгүүдийг хэрхэн сонгох, худгуудаа ямар түвшинд сэргээн засварлаж явах вэ гэдэг нь гол асуудал юм.



(3) Төслийн төлөвлөлтийн агуулга

1) Худаг байгуулалтын ажлын агуулга

Энэхүү төслийн хүрээнд шинээр гаргах, сэргээн засварлах худгууд нь 1) Өрөмдмөл, 2) Богино яндант, 3) Бетон хашлагат худаг гэсэн 3 төрлийн инженерийн худгууд юм. Худгийн байршлын хувьд малчид ба сумын захиргааны санал хүсэлтийг үндэслэн тогтоосон болно.

2) Худаг байгуулж эхлэх хүртэл хийгдсэн ажлууд

Туршилтын судалгааны объект болох шинээр гаргах, сэргээн засварлах худгуудыг малчдаас ирүүлсэн санал хүсэлтийг үндэслэн сонгосон болно. Малчдаас нийт 49 санал хүлээн авсан .

Хүснэгт 4.6.1 Төслийн санал дэвшүүлсэн байдал

		Ирүүлсэн саналын тоо			
		Эрдэнэ	Улаанбадрах	Хөвсгөл	Нийт
Худаг байгуулалт	Шинээр байгуулах	4	4	2	10
	Сэргээн засварлах	8	10	11	39

Эдгээр саналуудад бүлгийн бүтэц бүрэлдэхүүн, төслийн зорилго, тулгамдсан асуудлууд ба тэдгээрийг шийдвэрлэх арга зам, зардал хариуцах талаарх саналаа бичсэн байлаа. Мөн, бүлгийн үйл ажиллагааны туршлага, гишүүдийн суурьшил тархалт, бэлчээр ашиглалтын байдал зэргийг тодруулах хялбар асуулга судалгааг төслийн саналуудыг гаргаж ирэх үеэр нь давхар явуулсан. Үүний дараагаар судалгааны багаас худгуудыг сэргээн засварлах боломж (2.5.3 Мал услах байгууламж (2) Услах байгууламжийн эвдрэл гэмтэл болон сэргээн засварлах арга гэсэн хэсэгт тодорхойлсон шалгуурын дагуу сэргээн засварлах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргасан болно), бэлчээрийн байдал, өвс ургамлын төрөл зүйл, ашиглалтын байдал зэргийг газар дээр нь очиж магадлан, ажил хийгдэх худгуудыг хэрхэн сонгох талаар сумын ЗДТГ-тай зөвлөлдсөн ба төслийн саналыг дүгнэх шалгуур (4.4 Туршилтын төслийг хэрэгжүүлэх арга зам (3) Төслийн саналын сонгон шалгаруулалт) -т тулгуурлан судалж үзсний дүнд дараахь хүснэгтэд үзүүлсэн 19 худгийг сонгосон болно.

Бүх бүлгүүд дээр худаг байгуулалтын ажил эхлэхээс өмнө Үйл ажиллагааны Төлөвлөгөө боловрсуулах сургалт (PO work shop) зохион байгуулж, бүлэг тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, уг төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах тухай малчны бүлэг, сум ЗДТГ, судалгааны багийн хамтарсан санамж бичиг (гэрээ) (Хавсралт М-ийг үзнэ үү) үйлдсэн болно. Санамж бичигт доорх 2 асуудлыг тодорхой тусгасан. Үүнд:

- Малчдын бүлэг худгийн ашиглалт хамгаалалт, засвар үйлчилгээний сан байгуулах

- Малдчын бүлэг худаг байгуулалтын ажлын зардлын тодорхой хэсгийг хариуцаж, худгийн ажил эхлэхээс өмнө эхний төлбөрийг хийсэн байх.

Хүснэгт 4.6.2 Сонгон шалгаруулсан худгийн төслийн саналууд

Сум	Худгийн дугаар	Ажлын төрөл	Худгийн төрөл	Гүн (м)
Эрдэнэ	Өлзийт(Бүрдэнэ)	Шинээр байгуулах	Гүний худаг	50
	Цант	Шинээр байгуулах	Гүний худаг	80
	Бүхэл -2	Сэргээн засварлах	Гүний худаг	100
	Дөрвөлж	Сэргээн засварлах	Бетон хашлагат	8
	Бутын хоолой	Сэргээн засварлах	Гүний худаг	120
	Зүүн хур	Сэргээн засварлах	Гүний худаг	101.2
Улаанбадрах	Өвгөн мод	Шинээр байгуулах	Гүний худаг	60
	Ташаа	Шинээр байгуулах	Гүний худаг	150
	Талын бууц	Шинээр байгуулах	Гүний худаг	140
	Хоолой хонд	Сэргээн засварлах	Бетон хашлагат	6.9
	Хөх ам	Сэргээн засварлах	Гүний худаг	66.7
	Шувуун	Сэргээн засварлах	Гүний худаг	93
	Цайдам	Сэргээн засварлах	Гүний худаг	90.3
Хөвсгөл	Яст	Шинээр байгуулах	Гүний худаг	120
	Хярс	Сэргээн засварлах	Гүний худаг	43.3
	Шувуун тойром	Сэргээн засварлах	Гүний худаг	170
	Талын цагаан	Сэргээн засварлах	Гүний худаг	94
	Талын дов	Сэргээн засварлах	Гүний худаг	150
	Татаалын гол	Сэргээн засварлах	Гүний худаг	120

3) Барилгын ажлын хяналт

а) Барилгын ажлын тендер

Худаг шинээр гаргах, сэргээн засварлах барилгын ажлыг 2003 оны 9-11 сарууд ба 2004 оны 4-6 саруудад 2 хуваан явуулсан. 19 худгийн 2-т нь малчдын бүлэг зардал хариуцахаас татгалзсан тул нийт 17 худаг (сэргээн засварлах 13, шинээр барих 4) дээр барилгын ажил явагдлаа (Барилгын ажлын тэмдэглэлийг "Хавсралт С: Худгийг шинээр барих болон сэргээн засварлах ажлын тэмдэглэл" гэсэн хэсгээс үзнэ үү).

2 удаагийн барилгын ажлыг 2-улангийнх нь гүйцэтгэгчээр монголын худаг усны мэргэжлийн компаниуд гардан ажилласан. ХХААЯ-тай зөвлөлдсөний үндсэн дээр техникийн боломж бүхий худаг гаргах барилгын ажлын гүйцэтгэгч компаниудыг сонгож, техникийн шаардлагыг тайлбарлан танилцуулж, үнийн санал гаргуулан авсны үндсэн дээр сонгон шалгаруулсан. Ингэхдээ болж өгвөл орон нутгийн худаг усны мэргэжлийн компанийг тендерт оролцуулах нь худгуудын цаашдын засвар арчлалтын үйл ажиллагааг явуулахад дөхөмтэй байхаар байсан ("4.7.1 Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн төслийн үнэлгээний тойм, 2-7 Сургамж" гэсэн хэсгийг үзнэ үү.) хэдий ч эхний удаад гэрээ байгуулах хэлэлцээр хийх үед техникийн тал дээр санал нийлээгүй, 2 дахь удаад өгсөн үнийн санал нь тендерт шалгарч чадаагүй, Улаанбаатар ба Төв аймгийн компаниуд шалгарсан болно. Барилгын ажлын тендерт доорх зүйлсийг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

- Монголд, барилгын ажилд хуучирсан материал ашиглах зэрэг урьдчилан төсөөлөөгүй асуудал гарч ирэх явдал байдаг тул техникийн шаардлагыг урьдчилан сайтар тодорхойлж өгөхийн хамтаар тендерийн дараах үнийн хэлэлцээрийн үеэр шаардлагатай асуудлуудыг сайтар тодруулж, барилгын ажлын чанарыг ажлын талбар дээр нь байнга шалгаж байх.
- Орон нутгийн гүйцэтгэгчийг аль болох оролцуулах. Үүний тулд техникийн шаардлага, тендерийн бичиг баримтыг төрөлх хэлээр нь боловсруулах болон хамтран ажиллах (JV) зөвшөөрөл авах зэрэг нэмэлт ажлуудыг хийх шаардлага гарна. Гэхдээ аймаг бүрт ганц ганцхан л ийм компани байдаг тул тендерийн нөхцөлд үүнийг оруулахад (тендерт өрсөлдөөн байх ёстой учир) бэрхшээлтэй байдаг.

б) Тоног төхөөрөмжийн захиалга

Барилгын ажилд хэрэглэх тоног төхөөрөмжийг монгол орны баруун хэсгийн нутагт Азийн хөгжлийн банкны төслийн ажилд оролцсон туршлага бүхий "Grundfos" компани хариуцсан ба уг тоног төхөөрөмжөө Сингапураас оруулж ирсэн тул үүнд хамгийн багадаа 1 сар орчим хугацаа зарцуулагдсан. Бусад компаниудын хувьд ч ойролцоо хугацаа зарцуулдаг бололтой. Иймд газар дээрх судалгааны ажлын 3 сар орчмын хугацаанд барилгын ажлын гүйцэтгэгч сонгох, тоног төхөөрөмж суурилуулах ажлуудыг амжуулахын тулд барилгын ажлыг захиалсны дараа шууд тоног төхөөрөмжөө үргэлжлүүлэн захиалах шаардлага гарсан. Ингэж урьдчилан захиалсан тоног төхөөрөмж нь бодит байдал дээр худгуудынхаа хүчин чадалд таарахгүй болсон тул тоног төхөөрөмж суурилуулах ажлыг дараагийн удаагийн газар дээрх судалгааны ажлын үеэр явуулахаас өөр аргагүй байдалд хүрсэн.

Барилгын ажлын хэмжээ ихэнх тохиолдолд ус өргөх туршилтын үр дүнг харгалзан тохиромжтой хүчин чадал бүхий насосыг оролцуулсан иж бүрдэл тоног төхөөрөмж захиалах талаар судалж үзэж болох хэдий ч бага хэмжээний барилгын ажлын хувьд насосны хүчин чадлыг худагт нь тохируулан захиалж чадахгүй байх магадлалтай. Уг нь аль болох ус өргөх туршилтын үр дүнг харж байж насосныхоо техникийн шаардлагыг гаргаж ирэх нь зүйтэй юм. Ингэж чадвал худгийн ба насосны хүчин чадал харилцан таарах тул зардал бага гарах ба худаг нь ундарга сайтай байлаа ч насосны шахах ус бага байх явдлаас сэргийлж чадах юм. Иймээс бидний санал болгож байгаачлан (5.7 Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө) барилгын ажлын дараа тоног төхөөрөмжийн тендерийг зарлах байдлаар ажлыг 2 үе шатанд хуваан явуулах нь хугацаа шаардагдах хэдий ч бүтээмж сайтай байх юм.

Хүснэгт 4.6.3 Туршилтын төслийн хүрээнд явагдсан барилгын ажлуудын биелэлт

Сумд	Худгийн нэр	Ажлын төрөл	Барилгын ажлын хэрэгжилт
Эрдэнэ	Өлзийт (Бүрдэнэ)	шинээр гаргасан	2003 онд өрөмдөж, тоног төхөөрөмж суурилуулсан
	Цант	шинээр гаргасан	2003 онд худаг гаргахад амжилтад хүрээгүй, 2004 онд өрөмдөж, тоног төхөөрөмж суурилуулсан.
	Бүхэл-2	сэргээн засварласан	2003 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Дөрвөлж	сэргээн засварласан	2003 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Бутын хоолой	сэргээн засварласан	2004 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Зүүн хүр	сэргээн засварласан	2004 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
Улаанбадрах	Өвгөн мод	шинээр гаргасан	2003 онд өрөмдөж, 2004 онд тоног төхөөрөмж суурилуулсан
	Ташаа	шинээр гаргасан	Малчдын бүлэг зардал хариуцахаас татгалзсан тул ажил явагдаагүй.
	Талын бууц	сэргээн засварласан / шинээр гаргасан	2004 онд сэргээн засварлаад амжилтад хүрээгүй тул шинээр өрөмдөж, тоног төхөөрөмж суурилуулсан.
	Хоолой хонд	сэргээн засварласан	2003 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Хөх ам	сэргээн засварласан	2003 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Шувуун	сэргээн засварласан	2004 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Цайдам	сэргээн засварласан	2003 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
Хөвсгөл	Яст	шинээр гаргасан	2004 онд өрөмдөж, тоног төхөөрөмж суурилуулсан.
	Хярс	сэргээн засварласан	2003 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Шувуун тойром	сэргээн засварласан	Малчдын бүлэг зардал хариуцахаас татгалзсан тул ажил явагдаагүй.
	Талын цагаан	сэргээн засварласан	2004 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Талын дов	сэргээн засварласан	2004 онд тоног төхөөрөмж суурилуулсан.
	Татаалын гол	сэргээн засварласан	2004 онд тоног төхөөрөмж суурилуулсан.

4) Барилгын ажлын зардлаас малчдын хариуцах хэсэг

Малчдад худагтаа эзний ёсоор хандах сэтгэл зүйг төлөвшүүлж, ашиглалт хамгаалалтын үйл ажиллагааг нь идэвхжүүлэхийн тулд тэднээр худаг байгуулалтын ажлын зардлын тодорхой хэсгийг хариуцуулахаар төлөвлөсөн.

2003 онд явагдсан худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажлын үеэр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалт (PO Workshop)-аар дамжуулан судалгааны багаас худгийг засварлах ба харин мал услах онгоц, худгийн хашааг засварлах, барих ажлыг малчид хариуцах тохиролцоонд хүрсэн. Гэвч хэрэг дээрээ сургалтын үед тохиролцсон ажлын хуваарийг малчид заавал хэрэгжүүлэх ёстой гэж ухамсарлаагүй, худгаа л ашиглаж чадахуйц байдалтай болгоод авбал амласан амлалтаа биелүүлэхгүй байсан ч хариуцлага хүлээхгүй байж болохоор байсан зэргээс шалтгаалан малчдын хариуцах ажлын хэсэг биелэгдээгүй болно.


Хүснэгт 4.6.4 Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалтын үеэр тохиролцсон малчдын хариуцах ажлын хэсэг ба 2004 оны байдлаарх тэдгээрийн биелэлтийн байдал

Сумд	Худгийн нэр	Мал услах онгоц		Насосны байшин		Хашаа	
		Төлөвлөлт	Биелэлт	Төлөвлөлт	Биелэлт	Төлөвлөлт	Биелэлт
Эрдэнэ	Өлзийт (Бүрдэнэ)	Шинээр барих 1м ³ ,	хуучин поошиг тайрч тавьсан	Барихыг хүсэж байгаа хэдий ч малчид дангаараа чадахгүй тул сумаас туслалцаа авахыг хүссэн	биелэгдээгүй	Барихыг хүсэж байгаа хэдий ч малчид дангаараа чадахгүй тул сумаас туслалцаа авахыг хүссэн	Биелэг дээгүй
	Бүхэл-2	Шинээр барих	биелэгдээгүй	Байшинтай	Буулгаад дахин барьсан, цэвэрлэгээ хийх шаардлагатай	Санал гараагүй	/
	Дөрвөлж	Хуучныг засах	зассан	Барих санал гараагүй	/	Санал гараагүй	/
Улаан бадрах	Хоолой хонд	Хуучныг засах (600 л)	зассан	Барихыг хүсэж байгаа, ЖАЙКА-гаас тусламж хүссэн		20м	Биелэг дээгүй
	Цайдам	Шинээр тавих (800л) (хуучин янданг дахин ашиглаад)	хуучныг зассан	Байшинтай		Төмөр хашаа	Биелэг дээгүй
	Хөх ам	Хуучныг засах	зассан	Барихыг хүсэж байгаа, аймаг буюу суманд хандах бодолтой		Санал гараагүй	/
Хөвсгөл	Хярс	Хуучныг засах	биелэгдээгүй	Малчид дангаараа барих боломжгүй		30м	Биелэг дээгүй

Дээр өгүүлсэн нөхцөл байдал үүссэн тул 2004 онд малчдаар барилгын ажлын зардлын тодорхой хэсгийг хариуцуулах аргад шилжсэн (Үүний дараа малчдаар ажлын зардлын тодорхой хэсгийг хариуцуулах тухай улсаас албан ёсны шийдвэр гаргасан ба энэ тухай хойно өгүүлнэ). Хариуцах зардлын хэмжээний хувьд 2004 оны байдлаар худаг байгуулалтын ажил явуулж буй олон улсын байгууллага, доноруудын баримталж буй хариуцуулах зардлын хэмжээ зэргийг харгалзан үзэж доорх байдлаар тогтоосон. Үүнд:

- Өрөмдмөл болон богино яндант худагт 1,500,000 төг
- Бетон хашлагат худагт 1,000,000 төг.

Энэхүү хариуцах зардлаа 5 жилийн хугацаанд, хойно өгүүлэх “Сум хөгжлийн сан”-д эргүүлэн төлнө. Тэрчлэн малчдын орлого жилд 2 удаа бөөнөөр ордгийг харгалзан төлбөрийг жилд 2 удаа хуваан хийхээр зохицуулсан. Ингээд уг ажлыг хэрэгжүүлэхийн тулд барилгын ажил эхлэхийн өмнөх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалтаар зардал хариуцалт, “Сум хөгжлийн сан”, бүлэгтээ цаашдын үйл ажиллагаанд зориулсан хуримтлал үүсгэж явах нь чухал болох талаар малчдын бүлгүүдэд тайлбар хийж, зөвхөн зардал хариуцах талаар тохиролцоонд хүрсэн бүлгийн худагт насосыг суурилуулж өгсөн.



Зураг 4.6.1 Насос суурилуулах хүртэл явагдах ажлын дараалал ба зардал хариуцах байдал

2005 оны 6 сард ХХААЯ, БОЯ, СЭЗЯ-ны сайд нарын хамтарсан шийдвэрээр инженерийн худгийг шинээр барих, сэргээн засварлах ажлын зардлын тодорхой хэсгийг уг худгийг ашиглах малчдаас гаргуулахаар болсон. Уг шийдвэрийг үндэслэн төслийн хүрээнд байгуулсан худгуудын малчдын бүлгийн хариуцах зардлын хэмжээг өөрчилөн тогтоосон.

Дээрх шийдвэрийн дагуу малчдын хариуцах зардлын доод хэмжээ нь 300,000 – 600,000 төг байхаар байгаа бөгөөд 2005 оны 9 сарын байдлаар энэхүү шинэчилсэн хариуцах зардлыг төлсөн малчид 4 байгаа. Дараахь шалтгааны улмаас эхлээд шинэ журамд тусгагдсан зардлын жишиг хэмжээг баримтлан худаг тус бүр дээр гарч болох зардлыг тооцоолон, үүнийгээ баримжаалан төслийн хүрээнд малчдын бүлгийн хариуцах зардлыг худгийн төрөл тус бүрээр нэг адил хэмжээнд байхаар тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

- Зардлын хэмжээг худаг тус бүрээр тогтоовол усны төвшин нь доор худаг болон шинэ худаг ашигладаг малчдын бүлгийн хариуцах зардал өндөр гарна. Гэвч зардлын хэмжээ, худгийн хүчин чадалтай шууд хамаарахгүй юм.
- Өнгөрсөн хугацаанд төслийн хүрээнд малчдын бүлгүүдтэй тохиролцсоны үр дүнд уурхайн худаг, ерөмдмөл худаг тус бүрээр 2 төрлийн зардлыг тогтоон мөрдөж ирсэн юм. Иймд төслийн нэгдмэл байдлыг хангах үүднээс зардлын шинэчилсэн хэмжээг 4 уурхайн худаг, гүний худаг тус бүрээр нь тогтоовол малчид ойлгон хүлээж авах үндэслэлтэй юм.

Аймаг, сумдын ЗДТГ-уудтай хийсэн уулзалт, сумын худгийн санд тодорхой хэмжээний эх үүсвэр хуримтлуулах шаардлагатай гэсэн сумдын ЗДТГ-ын хүсэлтийг харгалзан үзсэний үндсэн дээр малчдын бүлгийн хариуцах зардлын хэмжээг дараах байдлаар тогтоолоо. Үүнд:

- 1- Гүний өрмийн худаг 750,000 төгрөг
- 2- Уурхайн худаг 500,000 төгрөг
- 3- Төлбөр барагдуулах эцсийн хугацаа 2007 оны 12 сарын эцэс.

5) Сумын худгийн санг байгуулах

Худгийн засвар үйлчилгээтэй холбоотой малчдын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө сум болон аймгийн төсөвт тусгагддаггүй. Насос, цахилгаан үүсгүүр эвдэрсэн үед хэрэглэхийн тулд малчид дундын сан байгуулахаар шийдвэрлэж өгсөн боловч хангалттай хэмжээний хөрөнгө санд хуримтлагдахаас өмнө эвдэрсэн тохиолдолд засвар үйлчилгээ хийлгэх, шинэ тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах хөрөнгийг сум гаргаж чадахгүй үе бий.

Ийм тохиолдолд тусламж, дэмжлэг үзүүлэх чадавхийг бий болгох үүднээс сумдад "Сумын худгийн сан"-г байгуулсан. Энэ сангийн хөрөнгийн эх үүсвэр нь туршилтын төслөөр гаргасан худгуудийг ашиглах малчдын бүлгүүдээс барилгын ажлын зардлын тодорхой хэсгийг буцаан төлж буй төлбөрийн мөнгө байх юм. Сум бүр худгийн сангийнхаа журмыг баталсан (Хавсралт М).

Зорилго: Цаашид нийт сумын хэмжээнд худаг байгуулалтын ажлыг өргөжүүлэн хөгжүүлэх

Үйл ажиллагаа: Дараахь тохиолдолд малчдын бүлгүүдэд хөрөнгө мөнгөний тусламж, дэмжлэг үзүүлэх.

- Сумын инженерийн худгийн сэргээн засварлах ажлын судалгаа, сэргээн засварлах ажил явагдсан үед,
- Суманд гар худгийг сэргээн засварлах, шинээр байгуулах ажил явагдахад,
- Одоо ашиглагдаж буй худгийн насосыг засварлах, шинэчлэн солиход хөрөнгө мөнгө шаардагдсан үед,
- Худаг байгуулалттай холбоотой бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд.

6) Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төслийн хүрээнд боловсруулсан бэлчээрийн менежментийн төлөвлөгөө нь худаг байгуулалттай нягт уялдаа холбоотой юм. Худаг байгуулах газрыг сонгохдоо бэлчээрийн менежментийн асуудлыг чухалчлан үзэж, малчдын улирлын чанартай нүүдлийг идэвхжүүлэхийн тулд ашиглалтгүй ба бага ашиглагдсан газрыг эзэмших, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахын тулд усжуулалтын үр ашгийг дээшлүүлэх гэсэн 2 гол зүйлийг харгалзан үзсэн болно.

7) Төслийг хэрэгжүүлэх явцад тулгарах асуудал, шийдвэрлэх арга зам

(Худгийн ашиглалтанд гарч ирж болзошгүй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам)

Гарч ирж болзошгүй асуудлууд	Асуудал гарч ирэх нөхцөл	Шийдвэрлэж болох арга зам
Худгийн операторын ажлын ачаалал их, байнга худаг дээрээ байж чадахгүйгээс малаа усалж чадахгүй тохиолдол их байдаг.	Малчдын бүлэг төрөл садан, айл саахалтын холбоогүй, тус тусдаа амьдрал ахуйгаа зохицуулдаг гишүүдээс бүрдсэн, малын тоо олон.	Операторыг цалинжуулна. Эсвэл хүн хөлсөлж ажилуулах. Хүн бүрт мал услах аргыг зааж өгөх. Мал услах цагийн хуваарийг гаргаж мөрдөх.
Худаг ашиглагдахгүй байх	Насос эвдэрэхэд арга хэмжээ авч чадахгүй байх	Сумын зүгээс мониторинг хийх. Сэлбэг нийлүүлэх, хадгалах бүтэц зохион байгуулалтыг бий болгох.
	Өөр уст цэг байхгүй болсон тохиолдолд ашиглахаар тооцож байгаа.	Албадан ашиглуулах боломжгүй. Ашиглалт хамгаалалтын хариуцагчийг нь тодорхой болгох.
Цахилгаан үүсгүүр эвдэрснээс насосыг ашиглаж чадахгүй байх	Ашиглалтын эхний үе шатанд эвдрэл гарах.	Худгийн ажлыг гүйцэтгэсэн компанитай холбоо барих
	Цахилгаан үүсгүүр эвдрэх	Цахилгаан үүсгүүрийн үйлдвэрлэгчээс сэлбэг захиалан авч сольж тавих, эсвэл цахилгаан үүсгүүрийг засварт өгөх

(Засвар үйлчилгээ, хадгалалт хамгаалалтад гарч ирж болзошгүй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам)

Гарч ирж болзошгүй асуудлууд	Асуудал гарч ирэх нөхцөл	Шийдвэрлэж болох арга зам
Малчид бүлгийнхээ худаг ашиглалтын санд мөнгө хуримтлуулахгүй байх	Малын тоо цөөхөн. Насос бага ашигладаг. Урт хугацаагаар худаг ашиглах бодолгүй. Худгаа тогтмол ашигладаггүй.	Санг бүрдүүлэхэд сумын зүгээс удирдамж, зааварчилга өгөх. Жил бүр ашиглахгүй байсан ч санд хуримтлал хийж байхыг зөвлөх. Бүлэг тус бүрийн сангийн хуримтлалын байдлыг бүлгүүдийн дунд мэдээлж байх.
1 өрх худгийн ашиглалтын бүх зардлыг даагаад дангаараа эзэмшиж байх.	Худгийг 1 айл (1 хот айл) ашиглаж, засвар үйлчилгээг нь хариуцдаг. Бусад айлууд тогтмол бус ашигладаг.	Ашиглалтын тарифыг нь тэнцүү, шударга тогтоох. Сумын зүгээс 1 хүний мэдлийн худаг болгохгүй байх талаар анхаарч, ойр хавийн малчдад ашиглахыг уриалах.
Тогтмол бус хэрэглэгчдээс худгийн ашиглалт хамгаалалтын зардлыг гаргуулж авч чаддаггүй.	Тогтмол бус хэрэглэгч нь төрөл садан учраас мөнгө нэхэж чаддаггүй.	Сум худгийн ашиглалтанд тэнцүү, шударга тариф тогтоож, малчдад мэдэгдэх.
Худгийн засвар үйлчилгээний зардал бүрдэхээс өмнө тоног төхөөрөмж эвдрээд шинэчилж чадахгүй байх.	Тодорхой нөхцөл байхгүй	Сумын худгийн сангаас зээл олгох боломжийг судалж үзэх.

(Бэлчээрийн менежментийн журам)

Худаг байгуулалт нь бэлчээр дэх уст цэгийн сонголтыг нэмэгдүүлэх хэдий ч малчдын жил тойрон нүүдэллэж ирсэн нутгийн хүрээнд шинэ худаг бий болсноор хэвшмэл болсон худгийн ашиглалтын байдалд ихээхэн өөрчлөлт гарах боломжтой гэж тооцоолж байна. Ингээд дор дурьдсан зүйлүүдийг судалж үзэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Тодорхой нэгэн худгийн эргэн тойронд малчдын төвлөрөл үүсэхээс сэргийлэх бүтэц, зохион байгуулалт

- Төвлөрөл үүссэн үед бэлчээрийн талхадлыг багасгах арга зам
- Ус, бэлчээр нь малчдын хооронд хэрүүл маргаан гарах шалтгаан болохгүй байх арга замыг санаачлах

Худаг байгуулсны дараа шийдвэрлүүштэй гол асуудлуудыг дор дурьдав.

- Зуслан (намаржаа) руу тохиромжтой цаг үед нүүдэл хийх, өвөлжөө (хаваржаа)-а бүрэн бүтэн байлгах
- Худгуудыг зүй зохистойгоор сэлгэн ашиглах
- Худгийн дагалдах байгууламжийг (усан сан, онгоц) бий болгох

(4) Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн төслийн биелэлт

1) Бэлчээр ашиглалтын бодлого, чиглэл

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх графикийг доор үзүүлэв.

	2003						2004											
	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Малчдын бүлэг				Худаг дарааллаар ашиглах журам боловсруулах				Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах хэмжих							Бэлчээрийн даацыг			
Засаг захиргааны нэгж (Аймаг, сум, баг)	Бэлчээрийн даацын хэмжилт		Судалгааны материал тараах, хурааж авах				Судалгааны материал тараах, хурааж авах				Нөөцийн зураг үйлдэх (3)		Хэмжилтийн аргыг сааж өгөх, судалгааны материал хурааж авах					
Жайкгийн судалгааны баг	Сургалт (1)		Сургалт (2)				Нөөцийн зураг үйлдэхэд дэмжлэг үзүүлэх				Мониторинг, дүн шинжилгээ		Нөөцийн хэмжилтийн сургалт (Сургалт (3))					

Зураг 4.6.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх график

Судалгааны багийн явуулсан бэлчээр ашиглалтын семинар дээр бэлчээрийн баялгийг хамтарч ашиглахын чухлыг тайлбарлан, малчдын бүлгийн бэлчээр ашиглалтын журмыг боловсруулахыг шамдуулж ирсэн. Гэвч судалгааны явцад, малчдын бүлэг дангаараа бэлчээр ашиглалтын журмыг боловсруулах нь хүндрэлтэй юм гэдгийг ойлгосон. Тиймээс бэлчээр ашиглалтын бодлогонд засвар оруулж, журам боловсруулахад баригдалгүйгээр, эцсийн зорилго болох бэлчээрийн баялгийг ашиглахад чиглэсэн, малчин болон засаг захиргааны нэгж харилцан авч ашиглаж болох мэдээллийн эх үүсвэрийг бий болгох замаар бэлчээр ашиглалтын системийг бий болгох болсон. Энд хамгийн чухал нь малчдад даалгах бус сумын захиргаа болон багийн дарга нар идэвхтэй оролцох явдал юм.

2) Бэлчээрийн даацыг хэмжих тухай семинар

2004 оны 9-р сард бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны нэг хэсэг болгон малчид болон хөдөө аж ахуйн түшмэд, багийн дарга нарт бэлчээрийн даацыг хэмжих аргын тухай семинар хийсэн. Семинарын дараа малчдын бүлгүүдэд худгуудын эргэн тойрны бэлчээрийн судалгааг хийх хүсэлт тавьсан. Ийм байдлаар малчид болон сумын захиргаа хамтран ажиллаж, хэрэгцээтэй мэдээллийг харилцан солилцох, ашиглах, хуримтлуулах зорилготой юм.

Энэхүү судалгааны аргын ерөнхий агуулгыг доор тайлбарлав.

Бэлчээрийн судалгааны хялбар арга:		
I) Модон саваагаар 1м x 1м квадратыг газар дээр тэмдэглэж үүсгэнэ. Газраа зориуд сонгохгүй. (Худгаас 1км ба 2 км-ийн зайтай тус бүр 3 цэгт-6 цэг* 60 хэмжилтийн цэг)		
II) 1м x 1м-ийн хүрээгээ 4 тэнцүү хэсэгт хувааж, өвсний бүрхэцийн (С) ойролцоо хэмжээг 6 шаттайгаар хэмжинэ. (Дараах хүснэгтийг харна уу)		
III) Квадрат дотор 5 ширхэг өвсний байгалин өндрийг хэмжинэ. (60 цэгт квадрат үүсгэх тул нийт 300 ширхэг өвсний өндрийг хэмжинэ.) Энэ үед ямар нэгэн тодорхой төрлийн өвсөнд баригдахгүй байх, мөн 30 сантиметрээс илүү диаметртэй ургамлыг сонгохгүй байх гэсэн 2 зүйлийг анхаарах хэрэгтэй		
IV) Хэмжилтийн үр дүнг тэмдэглэнэ.		
V) Энэ хэмжилтийг жилд 1 удаа, 8 сарын эцсээр хийнэ.		

Бүрхэц (6 шатлал ба тэдгээрийн үзүүлэлтүүд)		
Урга мал	%	Дундаж.
4	75-100%	87.5
3	50-75%	62.5
2	25-50%	37.5
1	5-25%	15.0
1'	1-5%	3.0
+	Өчүүхэн бага	0.5

3) Бэлчээрийн улирлын чанартай ашиглалт болон худгийн ажлын зардлын харилцан хамаарал (дүн шинжилгээ)

(Бэлчээрийн улирлын чанартай ашиглалт ба худгийг төрөлжүүлэн ангилсан нь)


Бэлчээрийн улирлын чанартай ашиглалтаас хамааран худгуудыг өвөл-хаврын болон зун-намрын, улирлын чанартай бус гэсэн 3 төрөлд ангилж болох юм. Төслийн хэмжээнд сэргээн засварлаж, шинээр барьсан 17 худгыг бэлчээр ашиглалтын байдлаар нь дараах ангилалд багтаан авч үзлээ. Үүнд:

- Өвөл-хаврын : Дөрвөлж (Эрд), Цайдам (Убд), Хоолойн хонд (Убд), Шувуун (Убд), Хөх Ам (Убд) (нийт 5 худаг)
- Зун-намрын : Зүүн хүр (Эрд), Бутын хоолой (Эрд), Талын цагаан (Хөв), Яст (Хөв), Хярс (Хөв) (нийт 5 худаг)
- Улирлын бус : Бүрдэнэ (Эрд), Бүхэл-2 (Эрд), Цант (Эрд), Өвгөн мод (Убд), Талын бууц (Убд), Татаалын гол (Хөв), Талын дов (Хөв) (нийт 7 худаг)

*Эрд...Эрдэнэ, Убд...Улаанбадрах, Хөв...Хөвсгөл

(Сэргээн засварласан ба шинээр барьсан худгуудын ашиглалтын хувь хэмжээ (бодит байдал) ба хариуцах зардлын харилцан хамаарал)


Малчдын бүлгүүдийн (нийт 116 өрх) бэлчээр ашиглалтын байдлыг үндэслэн худгийн төрөл тус бүрээр малчдын тухайн худгийн ашиглалтаас хамаарах хувь хэмжээ (ашиглалтын хувь хэмжээ) болон 1 өрхийн хариуцах зардлын хоорондын уялдаа холбоог дараахь зурагт нэгтгэн харуулав.



Зураг 4.6.3 Худаг ашиглалтаас хамаарах хувь хэмжээ ба 1 өрхийн хариуцах зардлын хоорондын уялдаа холбоо

Өвөл-хавар ашигладаг худгийн хувьд тухайн худгаас хамаарах хувь хэмжээ (37.1%)

болон 1 өрхийн хариуцах зардлын хэмжээ (59,114 төг) өндөр. Харин зун-намар ашигладаг худгийн хувьд тухайн худгаас хамаарах түвшин (19.4%)




Зураг 4.6.4 Худгийн ангилал тус бүрээр бүлгээс гарсан байгаа малчдын эзлэх хувь

болон 1 өрхийн хариуцах зардлын хэмжээ (14,444 төг) харьцангуй бага байна. Мөн 4.6.4 дүгээр зургаас үзэхэд зун-намар ашигладаг худгийн хувьд малчид бүлгээс гарах явдал хамгийн өндөр хувьтай (61.1%) байхад өвөл-хавар ашигладаг худгийн хувьд эсрэг буюу 0 хувьтай байгаа юм.

Эндээс өвөл-хавар ашигладаг худгийн бүлэг тогтвортой байх тусам худгийг идэвхтэй ашиглаж, тэр хэмжээгээр зардлын буцаан төлөлт сайн явагдаж байна гэж үзэж болох юм.

Нөгөө талаас зун-намар ашигладаг худгийг ашиглах хүсэлтэй малчид эхэндээ олон байсан боловч тэдгээрийн хагас нь сүүлдээ бүлгээсээ гарсан байна. Тиймээс буцаан төлөгдөөгүй зардлын хувь хэмжээ маш өндөр хувьтай байгааг 4.6.5 дугаар зургаас харж болно.



Зураг 4.6.5 Худгийн ангилал тус бүрээр төлөгдөөгүй байгаа зардлын хувь хэмжээ

Гэвч одоогоор бүлэгтээ байгаа нийт гишүүдийг (нийт 66 өрх) хооронд нь харьцуулан авч үзвэл буцаан төлөгдөөгүй байгаа зардлын хувь хэмжээ өвөл-хавар ашигладаг худгийн хувьд өндөр, зун-намар ашигладаг худгийн хувьд бага байх хандлага ажиглагдаж байна. Энэ нь зун-намар ашигладаг худгийн бүлгийн гишүүд хоорондоо хэл амаа ололцон, зардлаа төлөхөд оролцохыг хичээж буйн илрэл гэж үзэж болох юм. Өвөл-хавар ашигладаг худгийг голдуу ах дүү, төрөл садангийн холбоотой малчид ашигладаг. Бүлгийн бүрэлдэхүүний хувьд тогтвортой боловч дотроо аль биелэгжүү нь бүлгээ төлөөлөн холбогдох зардлыг төлөх нь их байдгаас шалтгаалж төлөгдөөгүй зардлын хувь хэмжээ нэмэгдэж байна.

4) Худгийн ашиглалт

1) Малчдын бүлгийн гишүүдийн тоо

Шинээр гаргасан болон сэргээн засварласан нийт 17 худгийг ашиглаж буй малчдын бүлгүүдийн гишүүдийн тооны өөрчлөлтийг 4.6.3 дугаар хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.6.5 Бүлгийн гишүүдийн тоонд гарсан өөрчлөлт
(2003 оны 11 сараас 2005 оны 9 сар)


	Гишүүдийн тоо			Бүлгээс гарсан гишүүд		Байнгын бус хэрэглэгчдийн тоо	
	Төсөл эхлэх үед (2003.11~2004.07)	2004.12	2005.09	Тоо	Хувь	2004	2005
Нийлбэр	116	72	66	-50	43.1%	5	14
Бүлгийн гишүүдийн дундаж тоо	6.8	4.5	4.1	-	-	-	-

* Гишүүдийн тоо анх байснаас өссөн

Туршилтын төсөл эхлэхэд 116 өрх байсан бол 2005 оны байдлаар 50 өрх бүлгээсээ гарснаар гишүүдийн тоо 43.1 % -иар буурч, 66 өрх бүлгийн зохион байгуулалтаар худаг ашиглаж байна. 1 өрхийн ам бүлийн бүтцээр авч үзвэл төсөл эхлэхэд байсан 6.8 хүнээс 4.1 хүн болж цөөрсөн байна. Бүлгийн гишүүн бус малчдын худаг ашиглалтын байдлыг бүрэн тодруулж чадаагүй боловч Ястын худгийг бүлгийн гишүүн бус 6 өрх 5 хоног ашигласан нь хамгийн өндөр үзүүлэлт байлаа.

ii) Малчдын бүлгээс уст цэгийг хослуулан ашиглаж буй байдал

Малчид улирлын чанартай отор нүүдэл хийх явцдаа хэд хэдэн уст цэгийг хослуулан ашигладаг. 2003 оны 1 сараас хойш малчдын бүлгийн гишүүдээс уст цэгийг хослуулан ашигласан байдлыг 4.6.6 дугаар зурагт харуулав (Татаалын гол, Бүрдэний худгийг оруулаагүй болно). Дунджаар Эрдэнэ суманд 4.4, Улаанбадрах суманд 6.1, Хөвсгөл суманд 4.9 уст цэгийг хослуулан ашигласан байх бөгөөд 3 сумын дунджаар 5.1 уст цэгийг хослуулан ашигласан байна.



Зураг 4.6.6 Хослуулан ашигласан уст цэгийн үзүүлэлт (2003-2005 оны нийлбэр байдлаар)

iii) Малчдын бүлгүүд шинээр гаргасан, сэргээн засварласан худгуудыг ашигласан хугацаа

Малчид өргөн уудам нутагт бэлчээр сэлгэн нүүхдээ уст цэгүүдийг хослуулан ашигладаг. Төслийн хүрээнд шинээр гаргасан, сэргээн засварласан худгуудыг ашигласан хугацааг дараахь зурагт нэгтгэн харуулав (Бүрдэнэ, Татаалын голын худгийг оруулаагүй.).

	Он	2003				2004												2005									
		9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	
Эрдэнэ	Цант																										
	Бүхэл																										
	Дөрвөлж																										
	Бутын хоолой																										
	Зүүн хүр																										
	Өвгөн мод																										
Улаанбадрах	Талын бууц																										
	Хоолойн хонд																										
	Хөх ам																										
	Шувуун																										
	Цайдам																										
Хөвсгөл	Яст																										
	Хярс																										
	Талын цагаан																										
	Талын дов																										


Тайлбар: Дөрвөлж, Хоолойн хонд нь уурхайн худаг тул сэргээн засварлахаас өмнө ашиглаж байсан.

Зураг 4.6.7 инээр гаргасан, сэргээн засварласан худгуудын ашиглалтын хугацаа

iv) Шинээр гаргасан, сэргээн засварласан худгийн ойр орчмын малын тоо толгойн өөрчлөлт (хонин толгойд шилжүүлснээр)


Нэг худгаас хамаарах хэмжээ (1 уст цэгийн ашиглалтын эзлэх хувь) өндөр байсан ч цөөхөн малтай, цөөн өрх ашиглаж байх тохиолдолд бэлчээр ашиглалтын тал дээр нэг их хүндрэлтэй асуудал гарахгүй болов уу. Иймд өрх бүрийн худаг ашиглалтын давтамж болон малын тооны үзүүлэлтээс сэргээн засварласан, шинээр гаргасан худаг тус бүрийн малын тоо толгойн өөрчлөлтийг нэгтгэн гаргав. Малын тоо толгой нь бэлчээрийн менежментийн 2 дахь үзүүлэлт юм.

(Эрдэнэ сум:)




Зураг 4.6.8 Шинээр гаргасан, сэргээн засварласан худгийн ойр орчмын малын тоо толгойн өөрчлөлт (хонин толгойд шилжүүлснээр)

(Улаанбадрах сум:)



Зураг 4.6.9 Шинээр гаргасан, сэргээн засварласан худгийн ойр орчмын малын тоо толгойн өөрчлөлт (хонин толгойд шилжүүлснээр)

(Хөвсгөл сум:)



Зураг 4.6.10 Шинээр гаргасан, сэргээн засварласан худгийн ойр орчмын малын тоо толгойн өөрчлөлт (хонин толгойд шилжүүлснээр)

v) Ашиглалтгүй худаг

Эрдэнэ сумын Бүрдэнэ, Хөвсгөл сумын Татаалын голын худгуудыг эзэмших малчдын бүлэг одоогоор байхгүй байна. Иймд энэ худгуудын цаашдын ашиглалтын асуудлыг холбогдох сумдын ЗДТГ-тай зөвлөлдөв.

а) Ашиглагдахгүй байгаа худгуудын өнөөгийн байдал

Бүрдэнэ болон Татаалын голын худгуудын онцлогийг 4.6.6 дүгээр хүснэгтэд харуулав. Эдгээр худгийн ойр орчмын бэлчээрийг өвөлд ашиглах боломжтой боловч усны чанар муу, ундны усны эх үүсвэр байхгүй, элсэрхэг хөрстэй зэрэг тааламжгүй нөхцлийн улмаас идэвхтэй ашиглагдахгүй байгаа юм.

Хүснэгт 4.6.6 Ашиглагдахгүй байгаа худгуудын үзүүлэлтүүд

	Бүрдэнэ	Татаалын гол
Байршил	Эрдэнэ сумын төвөөс 30 км газарт элсэн толгодын захад оршдог. Ирж очиход төвөгтэй.	Хөвсгөл сумын төвөөс 10 км газарт оршдог. Ирж очиход хялбар.
Бэлчээрийн онцлог	Элсэрхэг хөрстэй тал Жилийн турш ашиглах боломжтой Одоо ч гэсэн нөөц бэлчээр маягаар ашиглагддаг.	Элсэрхэг хөрстэй тал.Тэмээ, ямаа иддэг бут, сөөг голлон ургадаг. Хур тунадас элбэг үед хонь иддэг ургамал ч ургадаг.
Ойр хавийн уст цэг	Элсэн толгодын дунд байдаг булгийн ус нуур болон тогтоолдог. Булаг, нуурын ус гантай үед ширгэдэг.	Нэгдлийн үед ундны усанд ашигладаг гар худаг байсан боловч сүүлийн жилүүдэд хур тунадас багассанаас ширгэсэн.
Худаг байгуулсан зорилго	Булаг, нуур ширгэсэн үед ашиглах нөөц уст цэгтэй болохыг зорьсон. Унданд хэрэглэж болох худагтай болохыг хүссэн.	Тэмээний бэлчээр болгон ашиглахын тулд уст цэгтэй болохыг зорьсон.
Худаг ашиглагдахгүй байгаа шалтгаан	Худгийн ус их хэмжээний төмрийн агуулгатай болохыг худаг байгуулсны дараа тогтоосон. Мал усалж болох боловч малчид зардал хариуцах байдлаар ашиглахад хүрвэл арай ус сайтай худаг ашиглана гэсэн бодолтой.	Хүний унданд хэрэглэж болох уст цэг ойр хавьд нь байхгүй. Бэлчээрийн нөхцөл муу тул хонь бэлчээх боломжгүй. Урт хугацаагаар ашиглахад хэцүү. Бод мал ус уух үедээ л өөрөө худаг дээр ирдэг. Иймд хэн нэг хүн байнга худаг дээр байж байх шаардлагатай.

б) Асуудал шийдвэрлэхээр тавьсан санал

Энэ 2 худгийн насос, цахилгаан үүсгүүрийг зүй зохистой ашиглах үүднээс доорх 3 арга замыг судалж үзлээ.

- 1- Тоног төхөөрөмжийг татан авч төслийн хүрээнд байгуулсан бусад худгуудын нөөц төхөөрөмж маягаар ашиглах
- 2- Насосыг өөр худагт шилжүүлэн ашиглах
- 3- Онцгой нөхцөлд ашиглах зорилгоор тоног төхөөрөмжийг суурилуулсан чигээр нь орхих. Энэ тохиолдолд тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтыг сумын ЗДТГ хариуцах

Эхэн үедээ, эдгээр худгууд ашиглагдахгүй байхын зэрэгцээ бусад худгуудын тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтэл их хэмжээгээр гарч байсан тул -1- -т дурьдсан тоног төхөөрөмжийг татан авч төслийн хүрээнд байгуулсан бусад худгуудын нөөц төхөөрөмж маягаар ашиглах саналыг сумдын ЗДТГ-т тавьсан болно.

в) Сумдын удирдлагын хүсэлт

2005 онд Дорноговь аймгийн хэмжээгээр гангийн байдалтай байгаа тул сумдын удирдлага, тоног төхөөрөмжийг татан авч нөөц маягаар ашиглах саналыг сайшаан хүлээж аваагүй бөгөөд харин ч байгаа юмаа зүй зохистой ашиглах үүднээс худгийг хэзээ ч ашиглаж болох байдлаар хадгалж үлдэх хүсэлтээ илэрхийлэв.

Эцсийн дүнд энэ хоёр худгийн тоног төхөөрөмжийг татаж авалгүй, ойр хавийнх нь бэлчээрийг ашиглах боломжийг хадгалан үлдэхээр шийдэж, сумын ЗДТГ мал усалгааны тарифыг тогтоон, малчдаас холбогдох зардлыг хураан авч байх замаар ашиглаж явах чиглэлийг тогтоов.

б) Сумын худгийн сан

i) Буцаан төлөлтийн байдал

Худаг ашиглах малчдын бүлэг бүрдээгүй байгаа Хөвсгөл сумын Татаалын голын худгынхаас бусад худгийн малчдын бүлэг сумын худгийн санд төлбөрөө хийж байна. Харин Эрдэнэ сумын Бүрдэний худгийн хувьд анхнаасаа малчдын ба сумын захиргаа хамтран хариуцах тухай асуудлыг судалж үзэж байсан бөгөөд одоогоор зөвхөн сумын захиргааны хариуцах төлбөрийн хэсэг л төлөгдсөн байдалтай байна.

Эрдэнэ сумын хувьд сумын ЗДТГ-аас сан бүрдүүлэлтийн ажлыг идэвхтэй хийж байгаа тул буцаан төлөлтийн байдал сайн байна. 2 дахь удаагийн төлбөрөөс хойш дахин төлбөр хийгээгүй байгаа бүлгүүдээс үнэлгээний сургалт (workshop)-ын үеэр төлбөрөө үргэлжлүүлэн хийх бодолтой байгаа эсэхийг нь лавлаж тодруулсан.

Хүснэгт 4.6.7 Бүлгүүдээс сумын худгийн сангийн буцаан төлөлтийн байдал (төг)
(2005 оны 11 сарын байдлаар)

Эрдэнэ сум		Улаанбадрах сум		Хөвсгөл сум	
Өлзийт (Бүрдэнэ)	210,000 (сумын ЗДТГ)	Өвгөн мод	100,000	Яст	230,000
Цант	150,000	Талын бууц	100,000	Хярс	100,000
Бүхэл-2	420,000	Хоолой хонд	150,000	Талын цагаан	150,000
Дөрвөлж	380,000	Хөх Ам	250,000	Талын дов	390,000
Бутын хоолой	510,000	Шувуун	600,000	Татаалын гол	Төлөөгүй
Зүүн хүр	450,000	Цайдам	160,000	-	-
Нийт 2,120,000		Нийт 1,360,000		Нийт 870,000	

ii) Сангийн удирдлага, зарцуулалт

Сумын худгийн санд орсон нийт мөнгөний хэмжээ Эрдэнэ суманд 2,249,500 төг, Улаанбадрах суманд 1,360,000 төг, Хөвсгөл суманд 1,000,290 төг байна. Үүнд гар худгийн кампанит ажлын тоног төхөөрөмж ашигласны төлбөр ч багтаж байгаа юм. Сумын худгийн сангаас Улаанбадрах, Хөвсгөл сумд тус бүр 1 удаа зээл олгосон байна.

Хүснэгт 4.6.8 Сумдад төлбөр цугларсан, түүнээс хөрөнгө оруулалт хийсэн байдал

Төлбөр ба хөрөнгө оруулалтын төрөл		Эрдэнэ сум		Улаанбадрах сум		Хөвсгөл сум	
		Орлого	Хөрөнгө оруулалт	Орлого	Хөрөнгө оруулалт	Орлого	Хөрөнгө оруулалт
Орлого	Малчдын бүлгийн буцаан төлөлт	2,120,000	-	1,360,000	-	870,000	-
	Насос түрээслүүлсэн	82,760 (6 удаа)	-	-	-	-	-
	Трактор түрээслүүлсэн	40,000 (1удаа)	-	-	-	13,000 (9 удаа)	-
Хөрөнгө оруулсан	Насос худалдан авсан	-	-	-	500,000	-	-
	Усны ёмькость худалдаж авсан	-	-	-	-	-	200,000
Дүн		2,242,760	0	1,360,000	500,000	1,000,290	200,000

iii) Малчдын худгийн сангийн бүрдүүлэлт

Одоо ажиллаж байгаа 15 худгийг ашиглагч малчдын бүлгээс (17 худгаас огт ашиглагдахгүй байгаа Эрдэнэ сумын Бүрдэнэ, Хөвсгөл сумын Татаалын голын худгаас бусад) 7 бүлэг банкинд данс нээж хөрөнгө хуримтлуулж байна. Мөн эдгээрээс гадна банкинд данс нээгээгүй боловч зардал мөнгө цуглуулан, сан байгуулах гэж буй 4 бүлэг байгаа ба бүх бүлгүүдийн 2/3 нь хөрөнгө хуримтлуулах ажлаа эхлүүлээд байна. Workshop сургалтын үеэр бэлэн мөнгөө цуглуулаад байгаа бүлгүүдийг банкинд данс нээхийг уриаллаа.

Худгаа ашиглахгүй байгаа, эсвэл бүлэг байгуулагдаагүй байгаа худгууд дээр малчдын худгийн сангийн хөрөнгө цуглараагүй байдалтай байна.

iv) Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ

Өнгөрсөн хугацаанд эвдэрсэн моторыг Улаанбаатар руу засварт явуулсан тохиолдол дараах хүснэгтэд харуулсанчлан 9 удаа гарсан байна. Мөн 2 моторыг сумын засварчин засахаар болсон байна.

Хүснэгт 4.6.9 Улаанбаатар руу засварт явуулсан мотор, насос

Худгийн нэр	Гэмтлийн байдал, авсан арга хэмжээ	Тэмдэглэл
Цант	Ачаалал авмагц мотор унтардаг.(Хөдөлгүүрийн тохируулга хийсэн)	Үнэгүй зассан
Дөрвөлж	Шавхах насосны ёроолын шүүртэй тулгуур алга болсон	Үнэгүй зассан
Бутын хоолой	Хяналтын хайрцаг тоногдсон	Үнэгүй зассан
Талын бууц	Поршин гэмтсэн	75000 төгрөг
Цайдам	Генераторын катушк дотор шруп орсон байсан (Эхэн үедээ гэмтсэн)	Үнэгүй зассан
Яст	Генератор дотор элс орж эвдэрсэн.Агаар шүүгчийг сольсон.	115000 төгрөг
Яст	Хар угаа хаяад ажиллахаа больсон	Засаж байгаа.
Хярс	Поршингийн кольц эвдэрсэн. Сольж тавина.	Засаж байгаа
Бүхэл - 2	Ажиллахаа больсон	Малчид өөрсдөө засварт явуулж засуулсан. Зардал тодорхойгүй.

Хүснэгт 4.6.10 Суманд засварлах мотор

Худгийн нэр	Гэмтлийн байдал, авсан арга хэмжээ	Тэмдэглэл
Өвгөн мод	Хар утаа хаяад асахаа байсан.(Хөдөлгүүрийн сэлбэгийг сольж тавина.)	38000 төгрөг
Шувуун	Хар утаа хаяж асахаа байсан(Генераторын дотор гадны биет орсон байсан.) Хуучин сэлбэг сольж тавина.	Үнэгүй засна

Тэрчлэн мотор хэвийн ажиллаж байгаа боловч статерийн пластик дамар эвдэрсэн тохиолдол их гарсан байна. Энэ гэмтлийн шалтгааныг үйлдвэрлэгчээс лавлахад моторыг асаах үед статерт ихээхэн хүчээр үйлчилбэл амархан эвдэрдэг гэсэн хариу өгсөн болно.

Ийм жижиг гэмтлээс гадна дизель түлштэй моторыг өвөл асаахад хэцүү байдаг байна. Малчдын бүлгүүдээс моторын чанар муу гэсэн шүүмжлэл их ирж байлаа.

Иймд дараахь зүйлүүдийг анхааран хэвшүүлэхийг зааварчлав.

- Моторыг асаах үедээ гарын авлагын заалт, анхааруулгыг сайтар мөрдөх
- Өвлийн зориулалтын дизель түлш, моторын тосыг зүй зохистой тохируулан хэрэглэх

Тоног төхөөрөмжийн гэмтэл ихээхэн гарч байгаа тул сумдад засвар үйлчилгээний зохион байгуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэн, энэ зорилгоор тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сургалтыг зохион байгуулсан болно.

6) Худгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зохион байгуулалтад оруулах өөрчлөлт

Тус туршилтын төслөөр нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын явцад эвдрэл гэмтэл их гарч байна. Үүний нэг шалтгаан нь малчдад тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, засварын талаар зөвлөгөө өгөх, эвдэрсэн тоног төхөөрөмжийг нь засаад өгөх техникийн мэдлэг, чадвартай хүн ойр орчимд нь байдаггүйд оршиж байна. Мөн 2004 онд зохион байгуулсан "Санал солилцох уулзалт" болон 2005 оны сургалтын (workshop) явцад сумдад зохих сэлбэг хэрэгслийн нөөцийг бий болгож, үзлэг, засвар үйлчилгээ хийх хүнийг сургалтаар бэлтгэж өгөх хүсэлтийг малчдын зүгээс тавьж байсан болно. Гэвч төслийн хүрээнд харьцангуй цөөхөн тооны тоног төхөөрөмж нийлүүлэгдсэний улмаас нийлүүлэгч компани нь орон нутагт засвар үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтыг бий болгох сонирхолгүй байгаа юм. Ингээд тухайн сумандаа тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцах засварчныг бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар болов.

Сум тус бүрээс тодорхой хэмжээий техникийн мэдлэгтэй нэг нэг хүн сонгон авч сургалтанд хамруулахаар болов. Гэвч эхэндээ сумын засварчны мэдлэг, чадвар хүрэхгүй юман дээр мэргэжлийн байгууллагын тусламж, дэмжлэг шаардагдах тул

аймгийн ЗДТГ, орон нутгийн усны мэргэжлийн байгууллагатай зөвлөлдөн, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг цаашид дараах зохион байгуулалтаар хэрэгжүүлж явах тохиролцоонд хүрлээ.

- Төсөлд хамрагдсан сум тус бүрээс нэг нэг хүн, "Усжуулагч" компаниас нэг хүнийг оролцуулсан 3 өдрийн техникийн сургалтыг аймгийн төвд зохион байгуулж, зардлыг аймгийн ЗДТГ-аас гаргах
- Сумдын засварчдын мэдлэг чадвар хүрэхгүй зүйл дээр аймгийн "Усжуулагч" компанийн инженерүүд мэргэжлийн тусламж, дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах.

Сум бүрт Худгийн сангаас тодорхой хэмжээний хөрөнгө гарган амархан эвдэрч гэмтдэг сэлбэг хэрэгслийн нөөцийг бий болгох. Энэхүү сэлбэг хэрэгслийг сумын ЗДТГ, юмуу тоног төхөөрөмжийн засварчин хариуцан зарцуулж байхаар боллоо.

4.6.2 Малжуулах сангийн төсөл

(1) Зорилго ба үндсэн чиглэл

Эрүүл сүргээс бүрдсэн мал аж ахуйг хөгжүүлэх нь хөдөөгийн сумдын оршин тогтнох нөхцөл болно. Мал аж ахуйг хөгжүүлэхэд түүний үндэс суурь болох тодорхой тооны мал байх шаардлагатай. Малчид амьжиргааны эх үүсвэр болсон малаа өсгөн үржүүлэх явцад ямар нэгэн шалтгаанаар мал нь огцом хорогдож, хэрэглээ нь малын өсөлтөөс давж гарах тохиолдолд хохирлоо хялбархан нөхөж чадалгүй "ядуурлын тойрог"-т ордог. Нэгэнт ийм байдалд орвол дахиж сэхэхэд туйлын бэрхшээлтэй. Малжуулах сангийн төсөл нь ийм байдалд орсон малчдад дахин хөл дээрээ босох боломжийг олгож, сумын хэмжээнд ядуу малчдын тоог цөөрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой юм.

Мөн төслийг хэрэгжүүлэх явцдаа суманд сайн удам угсааны малын тоо толгойг олшруулах зорилт тавьж байна. Иймд боломжийн хирээр сайн удам угсааны малыг нийлүүлж, цаашид үр төл нь сумын хэмжээнд улам үржин олширч, сумын сүргийн чанар сайжрахад хувь нэмэр болох тал дээр нь анхаарах болно.

Энэхүү төслийг Эрдэнэ сумын ЗДТГ-аас санал болгосон бөгөөд цаашид сум бие даан хэрэгжүүлж явах юм. Санг бүрдүүлэх хөрөнгийн хэмжээ хязгаарлагдмал тул эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнгээс төслийн ирээдүй бүхэлдээ хамаарна. Төслийг цаашид улам өргөн хүрээнд амжилттай хэрэгжүүлэхийн тулд сангийн ашиглалтын эхний үе шатанд онцгой анхаарал тавих шаардлагатай. Иймэрхүү төсөл нь Эрдэнэ сумын хувьд анх удаагаа хэрэгжиж байгаа тул Сумын засаг захиргаа маш хариуцлагатай хандаж, туршлага хуримтлуулах явдал туйлын чухал.

Эрдэнэ суманд олон малчин малаа зудад хорогдуулсны дотор бүх малаа алдсан малчин ч цөөнгүй бий. Малжуулах сангийн үйл ажиллагаа нь эдгээр малчдыг

дэмжихэд чиглэх боловч төслийн хэрэгжилтийн үр дүн нь малчдын өөрсдийнх нь дадлага туршлага, хичээл зүтгэлээс ихээхэн хамаарах тул төсөлд хамрагдах малчдыг сонгох хатуу шалгуурыг тогтоохын хамт тэднийг дэмжих арга хэмжээг төслийн үйл ажиллагаанд тусгаж байгаа юмаа.

(2) Төслийн бүтэц, зохион байгуулалт

Малжуулах сангийн төслөөр тодорхой тооны малаар малчдыг санхүүжүүлж, тэндээс буцаан төлөгдөх малаар дараагийн малчныг санхүүжүүлэх замаар аль болох олон тооны малчин өрхийн малын тоо толгойг олшруулж явах бөгөөд төсөл үргэлжлэн явагдах нөхцлийг хангахын тулд багаар бодоход дараагийн жилд буцаан төлөгдөх малаар дахин санхүүжүүлэлт хийж болохуйц цар хүрээтэй байх шаардлагатай. Иймд уг төсөлд хамрагдах 6 малчин өрх тус бүрт 100 толгой¹, нийт 600 толгой² малын хөрөнгө оруулалтаар төслөө эхлүүлэхээр боллоо.

Эрдэнэ сумаас "Малжуулах сангийн ашиглалтыг журам"-ыг боловсруулж, уг төслийг удирдан явуулахаар болсон ба зохион байгуулалтын хувьд дараах байдалтай байна.

¹ Санхүүжүүлэлт хийсэн малын тооны хувьд хэд хэдэн арван толгойг нэгж хэмжээ болгон авах нь байдаг боловч зарлагдах малын тоог харгалзсан мал өсгөх төлөвлөгөө гарган судалж үзээд, бага хэмжээний аж ахуйтай малчдын хувьд 100 толгой мал зээлж аваад түүнийгээ 5 жилийн дотор буцаан төлж чадах юм байна гэдгийг магадлан 100 толгой мал байлгахгаар тогтсон.

² Нийтдээ багаар бодоход 600 орчим толгой мал байхгүй бол дараа жилийн санхүүжүүлэлтийн төлөвлөгөөний дагууд дараагийн малчныг санхүүжүүлэх тооны мал буцаан төлөгдөж чадахгүй.

Малжуулах сангийн бүтэц, зохион байгуулалт

Төсөлд хамрагдах малчинд тавигдах шаардлага:

- Тодорхой хугацааны туршид мал малласан туршлагатай байх
- Өөрийн гэсэн өвөлжөө, хаваржаа, худагтай байх.
- Хөдөлмөрийн бүрэн чадвартай байх
- Банкны зээл зэрэг өр төлбөргүй байх
- Ухамсар хариуцлага өндөртэй байх

- Малын даатгалд хамруулах
- Өвөлжилтөд зориулж тэжээл худалдаж авах

Малчин хүсэлт гаргана

Батлан даагч ба дэмжигч малчдын бүлэгтэй байх

Гаргасан хүсэлтийг багийн дарга нягтлан үзсэний үндсэн дээр нэрийг нь дэвшүүлнэ.

Сумын зөвлөлөөр оруулна

Малжуулах сангийн ашиглалтын журам

Малаар санхүүжүүлэх тухай гэрээ

Санхүүжилт хийх малыг бэлдэнэ

Хөрөнгө оруулалт

Эхний жил: 6 малчинд 600 толгой малын санхүүжилт хийгдэнэ.

5 жилийн хугацаанд 680 толгой тал буцаж төлөгдөнө.

Малчин А.

Малчин В

Малчин С

Малчин D

Малчин E

Малчин F

Буцаан төлөлт (төлөвлөлт: 118 толгой, биелэлт: 133 толгой)

2 дахь жилийн санхүүжилт

Малчин G

Биелэлт: 2 малчин

Буцаан төлөлт (150 орчим толгой мал)

Буцаан төлөлт (220 орчим толгой мал)

Санхүүжилтийн нөхцөл:

- Санхүүжилтийн дээд хэмжээ 100 толгой мал
- Жилийн 3%-ийн хүү
- Эм малыг эм малаар буцаах
- Хуцыг 2 жилээр сэлгэж ашиглах
- 2-5 жилд буцаан төлөх

3 дахь жилийн санхүүжилт

Малчин H

Малчин I

Буцаан төлөлт

4 дэх жилд санхүүжилт авах малчин

Малчин J

Малчин K

Сангийн ашиглалтын зорилго: Сангийн хөрөнгийг доорх зорилгод ашиглаж болно.

- Малын зээл
- Шилмэл омгийн мал зээлээр олгох

Сумын ЗДТГ-ын үүрэг:

- Сумын Засаг даргаас хөрөнгө ашиглалтын байдлын талаар мэдээлэл хийх
- Зээлд хамрагдах малчдад дэмжлэг үзүүлэх малчдын бүлгийг сонгох
- Малчдад зээлээр олгох малыг худалдан авч, хуваарилах
- Эргэн төлөгдсөн малд үнэлгээ, хяналт хийх
- Зээлд хамрагдсан малчдад тогтмол хугацааны болон мэргэжлийн зөвлөгөө өгөх
- Малын зээлийн буцаан төлөлтөд мониторинг хийх.

Малжуулах санг үүсгэн байгуулах хөрөнгө:

Эрдэнэ сумаас "Малжуулах сан"-гаас зээл олгоход тохиромжтой гэж үзсэн 6 малчинд өгөх санхүүжилтийг оруулаад, уг төслийг эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгийг ЖАЙКА-гаас гаргасан ба энэ нь уг санг үүсгэн байгуулах хөрөнгө болсон болно.

Малжуулах сангийн ашиглалтын хүү ба буцаан төлөлтийн арга хэлбэр:

"Малжуулах сан"-гийн зээл нь жилийн 3%-ийн хүүтэй байна. Буцаан төлөлтийг анх авсантай адил тооны малаар хийнэ. Гэхдээ үүнд тохирох мал байхгүй тохиолдолд сангийн ашиглалт хариуцагчийн зөвшөөрөлтэйгээр тухайн малын үнэлгээнд тохируулан бэлэн мөнгөөр төлж болно.

Сангаас зээл авах малчныг сонгох:

- Зээл авах малчин нь "Малжуулах сангийн зохион байгуулалт"-д үзүүлсэн нөхцлийг хангасан байна.
- Зээл авах малчны нэрийг багийн дарга дэвшүүлж, сумын дарга зөвшөөрсөн байна.
- Зээл авах малчин нь батлан даагчтай байх ба энэхүү батлан даагч нь бүх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Зээлээр олгох малын төрөл, тоо толгой:

100 хүртэл толгой малыг түүний төрлөөс үл хамааруулан олгоно. Малын зээл авах хүсэлтэй малчин тухайн үед байгаа малынхаа төрөл тус бүрийн тоо толгой болон ямар мал хэдэн толгой зээлж авах хүсэлтэй тухай учир шалтгааныг тайлбарласнаа

хавсарган багийн даргад хүсэлт гаргана. Үүнийг багийн дарга нягталж үзээд хүсэлтийг суманд уламжилна.

Мал буцаан төлөлтийн төлөвлөгөө:

Зээл авах малчин, малын төрөл тус бүрээр жилд зарлагдах, зарах, буцаан төлөх тоо толгойг тодорхойлсон төлөвлөгөө гаргаж, төслийн ашиглалт хариуцсан түшмэлээс зөвшөөрөл авах шаардлагатай. Энэ тооцоог хийхдээ мал онд оролт 90%, төлөлтийн хувьд хонь 90%, ямаа 85%-тай байхаар тусгана. Мөн, зээлээр олгогдсон хуцыг 2 жилийн дараа буцаах ёстой.

Мал буцаан төлөх хугацаа:

Малын зээл аваад буцаан төлөх хугацаа нь 2 жилээс дээш, 5 жилээс доош байна.

Мал буцаан төлөх хугацааг сунгах:

Буцаан төлөх хугацааны явцад учирсан байгалийн гамшиг зэргээс шалтгаалан зээлийг төлөвлөгөө ёсоор буцаан төлөх боломжгүй болох үед сумын Засаг даргын зөвшөөрөлтэйгээр буцаан төлөлтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болно.

“Малжуулах сангийн ашиглалтын журам”-д өөрчлөлт оруулах тухай:

Уг журмын дагуу шийдэхэд хүндрэлтэй асуудал гарсан тохиолдолд сангийн төлөөлөгч Эрдэнэ сумын Засаг дарга, төслийн ашиглалт хариуцагч ХАА-н түшмэл, сангийн хяналт хариуцагч төрийн сангийн төлөөлөгч нар хамтран ярилсаны үндсэн дээр уг журмыг өөрчилж болно.

Өвөлжилтөд зориулсан тэжээл худалдан авах хөрөнгийг зээлээр олгох:

Зээлд хамрагдсан малчдад малаа онд оруулахад нь зориулж малын тэжээл худалдан авах хөрөнгийг сумаас зээлээр олгоно.

Малын даатгалд хамруулах:

Зээлээр олгогдсон мал олон тоогоор хорогдох үед учрах хохирлын хэмжээг хамгийн бага байлгахын тулд тэдгээрийг малын даатгалд даатгуулах үүрэг өгнө.

(3) Төслийн төлөвлөлтийн агуулга

- 1) Төсөлд хамрагдах малчдын сонгон шалгаруулалт ба тэдгээр малчдын амьдралын өнөөгийн байдал

Эхний үе шатанд санхүүжүүлэгдсэн 6 малчны малын тоо толгойд 1999 оноос хойш гарсан өөрчлөлтийг 4.6.11 дүгээр хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.6.11 Төсөлд хамрагдаж буй малчдын малын тоо толгойд гарсан өөрчлөлт

Малчин	Он					Малчин	Он				
	1999	2000	2001	2002	2003		1999	2000	2001	2002	2003
A	140	31	62	0	32	D	206	164	140	78	82
B	163	133	122	90	66	E	54	41	61	48	57
C	143	113	67	22	36	F	406	276	295	86	75

Малчин А,С нар 1999 онд 140 малтай байсан бол 2002 онд А бүх малаа алдаж, С нь 22-хон толгой малтай үлдсэн байна. Түүнээс хойш төрөл садангуудынхаа дэмжлэг туслалцаатайгаар малын захтай залгаж, мал нь бага багаар өсөх хандлагатай байна. Малчин Е – ийн малын тоо 1999 оноос хойш цөөрсөөр байна. Малчин В, D болон F нарын мал 1999 оны үед нэлээд өсөж байсан боловч зудаар огцом хорогдсон байдалтай байна. Эдгээр малчид нь энэ маягаар малын тоо толгойг цаашид өсгөхөд туйлын бэрхшээлтэй нөхцөл байдалд ороод байгаа юм. Сумын захиргааны хувьд малжуулах сангийн төсөлд хамрагдах шаардлагатай (нийт малчдын 10%) 40 өрх байна хэмээн үзэж байгаа юм.

2) Сүргийн бүтэц ба мал өсгөх төлөвлөгөө

(Сүргийн бүтэц)

Зээлээр олгогдох малын тооны дээд хязгаарыг 100 малаар тогтоож, одоо байгаа малынх нь тоог харгалзан үзсэний үндсэн дээр уг малчинд дутагдаж буй малыг нь олгохоор төлөвлөсөн болно. Мөн, сумын малын чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор Сүхбаатар аймгаас нутгийн шилмэл омгийн 12 хуц худалдан авч, төсөлд хамрагдаж буй өрх бүрт 2 хуц олгохоор төлөвлөв. Мөн дээрх зорилгоор зээлээр олгогдох нийт эм хонины 20%-ийг Сүхбаатар аймгаас худалдан авч нийлүүлэх юм.

4.6.12 дугаар хүснэгтэд төсөлд хамрагдаж буй малчдын хувийн малын тоо болон зээлээр авсан малын тоог харуулав. (Малчдын хувийн малд эзлэх эр, эм малын харьцааг ойролцоогоор авав.)

Төсөлд хамрагдаж буй малчин өрх бүрт зээлээр олгох малын тооны дээд хэмжээ буюу 100, 100 мал, нийтдээ 600 толгой мал олгохоор төлөвлөсөн болно. Энэ удаагийн санхүүжүүлэлтэд тодорхой тооны адуутай айлууд хамрагдаж буй тул адуунаас бусад малыг олгож байгаа юм. Үүнд хонь 279, ямаа 297, үхэр 21, тэмээ 3 байна.

Төл мал дагалдуулсан зээл:

Зээлийн малд анхнаас нь төл малыг дагалдуулан олгосон бөгөөд нийт 258 төл мал байсан болно.

Хүснэгт 4.6.12 Малчдын хувийн болон зээлээр олгогдсон малын тоо

Малчин	Хувийн мал/ Зээлээр олгосон мал	Хонь				Ямаа				Үхэр			Адуу			Тэмээ			Нийт				Төл малыг оролцуулсан дүн
		Хүч	Эр	Эм	Нийлбэр	Ухна	Эр	Эм	Нийлбэр	Эр	Эм	Нийлбэр	Эр	Эм	Нийлбэр	Эр	Эм	Нийлбэр	Хээлтүү дэгч	Эр	Эм	Нийлбэр	
А	Зээл олгохоос өмнөх		4	8	12		8	10	18	0			2		2	0		0		14	18	32	178
	Зээлээр олгосон	2	8	42	52	1	6	37	44	0	3	3			0		1	1	3	14	83	100	
	Төл мал		26				17				3										46		
	Нийлбэр	2	12	50	64	1	14	47	62	0	3	3	2	0	2	0	1	1		28	101	132	
В	Зээл олгохоос өмнөх		5	12	17		10	19	29	2	2	4	5	8	13	1	2	3		23	43	68	213
	Зээлээр олгосон	2	6	32	40	1	9	45	55	0	4	4			0		1	1	3	15	82	100	
	Төл мал		5				38				4										47		
	Нийлбэр	2	11	44	57	1	19	64	84	2	6	8	5	8	13	1	3	4		38	125	168	
С	Зээл олгохоос өмнөх		17	17	34		16	30	46	1	1	2	2	3	5	1	3	4		37	54	91	204
	Зээлээр олгосон	2	6	32	40	1	9	45	55		4	4			0		1	1	3	15	82	100	
	Төл мал		0				10				3										13		
	Нийлбэр	2	23	49	74	1	25	75	101	1	5	6	2	3	5	1	4	5		52	136	191	
D	Зээл олгохоос өмнөх		8	17	25		10	21	31	5	5	10	4	4	8	4	4	8		31	51	82	252
	Зээлээр олгосон	2	5	43	50	1	4	45	50			0			0			0	3	9	88	100	
	Төл мал		38				32														70		
	Нийлбэр	2	13	60	75	1	14	66	81	5	5	10	4	4	8	4	4	8		40	139	182	
E	Зээл олгохоос өмнөх		10	20	30		7	18	25	1	1	2	5	8	13	2	3	5		25	50	75	214
	Зээлээр олгосон	2	5	48	55	1	4	36	40		5	5			0				3	9	88	100	
	Төл мал		17				17				5										39		
	Нийлбэр	2	15	68	85	1	11	53	65	1	6	7	5	8	13	2	3	5		34	138	175	
F	Зээл олгохоос өмнөх		2	4	6		17	26	43	2	2	4	2	2	4	0	0	0		3	16	81	200
	Зээлээр олгосон	2	8	32	42	1	8	44	53		5	5			0							43	
	Төл мал		23				15				5										157		
	Нийлбэр	2	10	36	48	1	25	70	98	2	7	9	2	2	4	0	0	0		39	115	157	
Нийт	Зээл олгохоос өмнөх	0	46	78	124	0	68	124	192	11	11	22	20	25	45	8	12	20	0	153	250	403	1261
	Зээлээр олгосон	12	38	229	279	6	40	251	297	0	21	21	0	0	0	3	3	18	78	504	600		
	Төл мал		109				129				20										258		
	Нийлбэр	12	84	307	403	6	108	375	489	11	32	40	20	25	45	8	15	23	0	231	754	1003	

Эх материал: Эрдэнэ сумын ЗДТГ, ЖАЙКА-гийн судалгааны бөг

(Буцаан төлөлтийн төлөвлөгөө ба жил бүр буцаан төлөх малын тоо)

Малчин тус бүрийн зээлээ буцаан төлөх төлөвлөгөөг 4.6.13 дүгээр хүснэгтэд харуулав. Цөөхөн малтай малчид эхнээсээ малаа өсгөхөд онцгой анхаарах шаардлагатай бөгөөд зээлээ 5 жилийн хугацаанд буцаан төлнө. Тодорхой тооны малтай малчдын хувьд зээлээр авсан малын тооноосоо хамааран 3 жилд буцаан төлөх боломжтой юм.

Хүснэгт 4.6.13 Мал буцаан төлөх төлөвлөгөө

Он	Малчин А	Малчин В	Малчин С	Малчин D	Малчин Е	Малчин F	Дүн
2005	12	13	36	13	18	26	118
2006	17	18	34	18	27	36	150
2007	26	47	27	25	32	37	194
2008	27	24	0	26	33	0	110
2009	32	34	0	33	0	0	99
Нийт	115	115	107	115	110	109	671

Жилд 3%-ийн хүү тооцоход зээлээр олгогдсон 600 малын оронд 671 мал буцаан төлөгдөнө.Бод малын хувьд зээлийн хүүг малаар тооцоход бэрхшээлтэй тул шаардлагатай үед бэлэн мөнгөөр тооцох нь зүйтэй юм. Эхний жилд 118 толгой мал буцаан төлөгдөх бөгөөд энэ нь дараагийн хүнд малын зээл олгох боломжийг бүрдүүлж байна.

Эхний жилийн буцаан төлөлтийн биелэлт:

Эхний жилд 118 толгой мал буцаан төлөгдөх байснаас 133 толгой төлөгдсөн байна.

3) Мал нийлүүлэх газар болон малын үнэ ханшийг тогтоосон нь

Эрдэнэ сумаас хүсэлт гаргасны дагуу 12 хуц (өрх бүрт 2 толгой) болон хонины 20%, 6 ухна (өрх бүрт 1 толгой) болон ямааны 20%-ийг тус тус шилмэл омгийн мал байхаар төлөвлөж, эдгээрийг Сүхбаатар аймгаас худалдан авсан.

Өөр аймагт мал худалдан авахдаа шилмэл омог, үүлдрийн мал болохыг нь нотолсон гэрчилгээ, мал эмнэлгийн үзлэгийн гэрчилгээ зэрэг нотолгоо баримтад тулгуурлан сонгон авахаас гадна вакцинжуулах, Эрдэнэ сумын нутагт орж ирээд мал эмнэлгийн үзлэг хийх шаардлагатай юм. Мөн урт замд олон цаг явах тул мал арчлах малчид дагалдан явах шаардлагатай юм.

Бусад малын хувьд сумын малчдад мэдээлэл тарааж аль болох сайн чанарын малыг хямд үнээр худалдан авахаар төлөвлөсөн. Ийм байдлаар суманд гаднаас олон тооны мал нийлүүлэгдэж, мал олон малтай малчнаас цөөн малтай малчинд шилжиж, сумын дотор малын дахин хуваарилалт явагдах юм.

Мал худалдан авахад шаардагдсан зардлын төлөвлөлт ба жинхэнэ гарсан зардлыг 4.6.14 дугаар хүснэгтэд үзүүлээ. Төлөвлөлт ба биелэлтэд онцын зөрөө гараагүй болно.

Хүснэгт 4.6.14. Мал худалдан авсан зардал

Зардал	Нэгж	Тоо, хэмжээ	Төлөвлөлт		Биелэлт		Тэмдэглэл (худалдан авсан газар)
			Нэгж (төг)	Нэгж (төг)	Нэгж (төг)	Нэгж (төг)	
I Шилмэл омгийн мал худалдан авсан				3,208,800		2,824,360	
1 Тээврийн зардал	бүрдэл	1		780,000		694,560	
2 Хуц	толгой	12	45,000	540,000	42,083	505,000	Сүхбаатар аймаг
3 Ухна	толгой	6	35,000	210,000	31,667	190,000	Сүхбаатар аймаг
4 Шилмэл омгийн хонь		24	33,000	792,000	30,000	720,000	Сүхбаатар аймаг
5 Шилмэл омгийн ямаа		30	28,000	840,000	22,267	668,000	Эрдэнэ сум
6 Вакцинжуулалт	толгой	72	150	10,800		10,800	
7 Мал эмнэлгийн үзлэг	бүрдэл	72	500	36,000		36,000	
II Энгийн мал худалдан авсан				19,415,000		18,226,040	
1 Хонь (эр)	толгой	38	40,000	1,520,000	31,737	1,206,000	Эрдэнэ сум
2 Хонь (эм)	толгой	205	30,000	6,150,000	26,663	5,466,000	Эрдэнэ сум
3 Ямаа (эр)	толгой	40	35,000	1,400,000	33,200	1,328,000	Эрдэнэ сум
4 Ямаа (эм)	толгой	221	25,000	5,525,000	22,647	5,005,000	Эрдэнэ сум
5 Үхэр (эм)	толгой	21	180,000	3,780,000	199,048	4,180,000	Эрдэнэ сум (2 толгойг Сүхбаатар аймгаас)
6 Тэмээ (эм)	толгой	3	280,000	840,000	250,000	750,000	Эрдэнэ сум
7 Тээврийн зардал	бүрдэл	1		200,000		291,040	
III Малыг даатгал				106,781		97,157	
IV Бусад зардал	бүрдэл	1				150,500	
V Нийт				22,730,581		21,298,057	

Эх материал: Эрдэнэ сумын ЗДТГ

Шилмэл омгийн мал худалдан авсан газар:

Шилмэл омгийн бүх малыг Сүхбаатар аймгаас худалдан авч чадаагүй тул шилмэл омгийн ямааг сайн үүлдрийн мал олонтой Эрдэнэ сумын хойд хэсгийн нутгаас худалдан авсан.

Хол газраас олон тооны мал авчрахад олон талын бэрхшээл учирдаг тул тухайн нутагт дутагдалтай байгаа шилмэл омгийн малыг ойр хавийн нутгаас худалдан авах арга замыг давхар судалж үзэх нь зүйтэй.

Төслөөр нийлүүлэгдэх малыг худалдан авсан хугацаа:

Эрдэнэ сумын хувьд цөөхөн ч гэсэн сайн үүлдэр угсааны малыг аль болох ойрын үед худалдан авах бодолтой байснаас гадна төсөлд хамрагдсан малчид ч гэсэн малаа эртхэн хүлээж аваад, арчилгаа маллагаа, нутаг усандаа дасгаж, өвлийн бэлтгэлээ хангах хүсэлтэй байсан боловч тухайн жилийн төлийг 8 сарын сүүл хүртэл эхээс нь салгаж болдоггүй, төлийг эхээс нь салгахгүй л бол нэг төллөсөн туршлагатай малыг худалдан авах боломжгүй зэргээс шалтгаалан төслийг хэрэгжүүлж эхлэх цаг хугацааг товлоход тодорхой бэрхшээл учирч байсан. Иймээс 7 сарын сүүлээр төлтэй нь хамт худалдан авсан.

4) Төслийн хэтийн төлөв

4.6.15 дугаар хүснэгтэд төсөл хэрэгжиж эхэлснээс хойш жил бүр буцаан төлөгдөх малын тоо болон тухайн үе шатанд шинээр зээлд хамрагдаж явах боломжтой малчдын тоог харуулав.

Хүснэгт 4.6.15 Буцаан төлөгдөх малын тоо болон шинээр зээлд хамрагдах боломжтой малчдын тоо

Жил	Буцаан төлөгдөх малын тоо						Шинээр зээлээр олгох боломжтой малын тоо	Шинээр зээлд хамрагдах боломжтой малчдын тоо
	Эхний жил	2 дахь жил	3 дахь жил	4 дахь жил	5 дахь жил	6 дахь жил		
1	118						118	1
2	150	23					173	2
3	194	29	34				257	3
4	110	38	43	50			241	2
5	99	21	55	64	47		286	3
6		19	31	83	60	56	249	3
7			28	47	77	71		
8				42	44	92		
9					39	52		
10						47		
	671	130	191	286	267	318	1324	14

* 2 дахь жилээс хойш буцаан төлөх малын тоог төслийн буцаан төлөлтийн %-д үндэслэн тооцсон болно.

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 1 жилийн дараа 118 мал буцаан төлөгдсөнөөр 2 дахь жилд зээлд шинээр 1-2 хүн хамрагдах боломжтой болно гэдэг нь бага тоо боловч 2 дахь жилээс хойш 2-3 хүн хамрагдах боломжтой болно. Ингэснээр эхний үе шатанд төсөлд хамрагдсан 6 малчныг оролцуулан 6 жилийн хугацаанд нийт 20 малчин малжуулах төслийн үр шимийг хүртэх боломжтой болно.

(4) Малжуулах сангийн төслийн биелэлт

1) Мал худалдан авах ажил

Мал худалдан авах хугацааны хувьд аль болох эртхэн малаа авъя гэсэн малчдын хүсэлтийг харгалзан үзсэн. Ингээд төл малыг эхээс нь салгадаг 8-р сарын сүүлээс өмнө малаа худалдан авч тараахаар болсон тул ихэнх эм малыг төлтэй нь хамт хуваарилж, зээл төлөх үед мөн төлтэй нь хамт буцаан авах нөхцлийг тавилаа.

Нутгийн шилмэл омгийн бүх малыг Сүхбаатар аймгаас худалдан авахаар төлөвлөж байсан боловч боломжгүй болсноос үүдэн шилмэл омгийн ямааг урьд өмнө Сүхбаатар аймгаас нутгийн шилмэл омгийн мал авч ирээд үржүүлж буй Эрдэнэ сумын зүүн хойд багийн 2 газраас авсан болно.

Зээлээр олгох малын бусад хэсгийг Эрдэнэ сумын мал олонтой 30 гаруй малчдаас худалдан авлаа. Ингэхдээ зарын дагуу багийн төвд малаа авч ирсэн хүмүүсийн малаас зээлд хамрагдсан малчид өөрсдөө малаа сонгож авснаас гадна мал худалдан авах комиссын гишүүд зээлд хамрагдсан малчидтай хамт малаа зарах боломжтой малчдынхаар явж газар дээр нь сонгон авлаа.

Сүхбаатар аймагт худалдан авсан малыг урьд нь вакцинжуулсан байсан тул дахин вакцин хийлгүй Эрдэнэ суманд авч ирснийхээ дараа вакцин хийсэн болно. Харин Эрдэнэ суманд худалдан авсан малын хувьд сумын мал эмнэлгээс газар дээр нь вакцинжуулалт хийлээ.

Зээлд хамрагдсан малчдын малыг сумын Засаг дарга, багийн дарга нар, ХАА-н түшмэл нарыг байлцуулан хуваарилж олгов. Нутгийн шилмэл омгийн малыг худалдан авснаас олгох хүртэл хугацаанд тэдгээрийг Эрдэнэ сумын 2 малчинд хөлс өгөн маллуулж байсны нэг нь хуц ухна дагнан малладаг малчин байв.

2) Малын даатгал

Малын даатгалын хувьд зээлээр олгох малын төрөлд багтаагүй адуу болон зээлээр олгох малд багтсан цөөн тооны тэсвэр тэвчээр сайтай тэмээнээс бусад 3 төрлийн бүх малыг хамруулав. Өөрөөр хэлбэл зээлд хамрагдаж буй малчдад анхнаасаа байсан мал болон зээлээр олгогдсон (адуу, тэмээнээс бусад) малыг хамтад нь даатгуулсан болно.

Эхний жилийн даатгалыг сумын ЗДТГ малчдын өмнөөс төлсөн бөгөөд 1 сарын 26 – нд болсон төсөлд хамрагдсан малчдын уулзалтын үеэр уг мөнгийг ноолуурын орлого ормогц малчдаас "Малжуулах санд" буцаан төлөх талаар тохиролцсон байна. 2005 оны 5 сарын сүүлийн байдлаар 4 өрх төлбөрөө хийж, 2 өрх төлөөгүй байдалтай байлаа.

Даатгалд хамрагдсан малын тоо: Хонь 430, ямаа 474, үхэр 33, нийт 937.

Даатгалд төлсөн мөнгө: 97157 төг (тариф: хонь 90 төг, ямаа 76,5 төг, үхэр 675 төг)

3) Өвс тэжээл

Ихэнх малчин өрхүүд өвөл, хаварт бэлэн мөнгөний гачигдалд орж, өвс тэжээл худалдан авах боломжгүй болдог. Иймд сумын ЗДТГ 2004-2005 оны өвөлжилтийн ажлын арга хэмжээний хүрээнд малын зээлийн төсөлд хамрагдсан малчдаас авсан захиалгын дагуу аймгийн Тэжээлийн фондоос хорголжин тэжээл, цэргийн ангиас өвс худалдан авч зээлээр олгосон бөгөөд өвс тэжээлийн үнийг хавар ноолуур зараад орж ирэх орлогоос буцаан төлөхөөр тохиролцсон байна.

Өвс тэжээл зээлээр олгосон болон түүнийг буцаан төлсөн байдлыг дараахь хүснэгтэд харуулав (2005 оны 5 сарын эцсийн байдлаар).

Хүснэгт 4.6.16 Өвс, тэжээл худалдан авсан, олгосон, буцаан төлсөн байдал.
(Нэгж:Төг)

Малчдын нэр	Тэжээлийн төрөл	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Зээлийн дүн	Буцаан төлөлт 5сарын эцсийн байдлаар
Малчин А	Тэжээл	5	7000	35000	48000	48000
	Өвс	10	1300	13000		
Малчин В	Тэжээл	2	7000	14000	44500	
	Өвс	10	1300	13000		
	Хивэг	5	3500	17500		
Малчин С	Тэжээл	5	7000	35000	61000	61000
	Өвс	20	1300	26000		
Малчин D	Тэжээл	3	7000	21000	53500	53500
	Өвс	25	1300	32500		
	Хивэг	5	2500	12500	Өөрийн мөнгөөр	
	Өвс	10	1000	10000	Өөрийн мөнгөөр	
Малчин E	Тэжээл	3	7000	21000	47000	
	Өвс	20	1300	26000		
Малчин F	Тэжээл	3	7000	21000	34000	34000
	Өвс	10	1300	13000		
Нийт	Тэжээл	21		147000	288000	196500
	Өвс	95		123500		
	Хивэг	5		17500		

Зээлээр олгосон өвсний үнийг 6 өрхөөс 4 өрх буцаан төлсөн, 2 өрх төлөөгүй байдалтай байсан. Төлөөгүй байгаа өрхүүд 6 сардаа багтаж төлөх бөгөөд хэрэв түүнээс хэтэрвэл сарын 3 хувийн хүү тооцохоор 1 сард төсөлд хамрагдсан малчидтай хийсэн уулзалтын үеэр тохиролцсон байна.

Төлөгдөөгүй төлбөр төлөгдсөн тухай:

1 малчин 7 сард, үлдсэн 1 малчин 10 сард төлж барагдуулсан байна.

4) Онд оролт, төллөлтийн хувь

Зээлээр олгосон малын онд оролтын бүх үзүүлэлтүүдийг 4.6.17 дугаар хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.6.17 Мал онд оролт, төллөлтийн хувь

Малчдын нэр	2004оны эцэст байсан мал	Хорогдсон малын тоо			Онц оролтын хувь (%)	Төллөсөн малын тоо					Мал төллөлтийн хувь (%) (Барагцаалсан тооцоо)	
		Нийт	Хонь	Ямаа		Нийт	Хонь	Ямаа	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1 Малчин А	165	3	1	2	98.2	77	38	36	3	-	76.0	76.6
2 Малчин В	203	0	-	-	100.0	119	49	67	2	1	111.4	104.7
3 Малчин С	190	4	2	2	97.9	114	40	70	3	1	81.6	93.3
4 Малчин D	236	0	-	-	100.0	111	47	57	6	1	78.3	86.4
5 Малчин E	177	1	-	1	99.4	88	40	43	4	1	80.0	81.1
6 Малчин F	190	3	1	2	98.4	74	30	40	4	-	83.3	57.1
Нийт	1161	11	4	7	99.1	583	244	313	22	4	85.6	83.5

(Эх сурвалж : Судалгааны багийн материал)

Онц оролт:

Бэлчээрийн байдал тааруу байсан хэдий ч 2004-2005 оны мал онд оролтын хувь харьцангуй өндөр байна. Төсөлд хамрагдсан 2 малчны мал огт хорогдоогүй байв. Мөн нийт сумын хэмжээнд мал онд оролтын хувь сайн байна.

Төллөсөн малын тоо ба төл авалтын хувь:

Зээлээр 600 том мал, 269 төл, нийт 869 мал олгосон болно. Төсөлд хамрагдсан малчид зээлийн малыг оролцуулаад нийт малаасаа 583 төл авсан нь зээлээр олгогдсон малын тоотой ойролцоо хэмжээнд очих юм.

Мал өсгөх төлөвлөгөөнд 249 хонь, 287 ямаа төллүүлэхээр тусгаснаас 244 хонь, 313 ямаа төллөж төллөлтийн дундаж хувь хонинд 79.5%, ямаанд 83.5% байлаа. Энэ мэтчилэн хүлээн авсан төлийн тоо, толгой бараг төлөвлөсөн хэмжээнд байгаа нь онд оролтын хувь өндөр байсантай холбоотой.

5) Хэрэглэсэн ба зарж борлуулсан малын тоо

Дараахь хүснэгтэд хэрэглэсэн болон зарж борлуулсан малын тоог харуулав.

Хүснэгт 4.6.18 Хэрэглэсэн ба зарсан малын тоо

Малчдын нэр	Хэрэглэсэн малын тоо					Зарсан малын тоо			
	Нийт	Хонь	Ямаа	Үхэр	Тэмээ	Нийт	Хонь	Ямаа	Үхэр
1 Малчин А	5	1	3	1	-	4	2	2	-
2 Малчин В	6	1	4	1	-	4	2	2	-
3 Малчин С	20	10	10	-	-	5	-	5	-
4 Малчин D	14	3	10	1	-	2	-	-	2
5 Малчин E	14	5	7	1	1	27	23	4	-
6 Малчин F	7	2	4	1	-	3	-	3	-
Нийт	66	22	38	5	1	45	27	16	2

(Эх сурвалж : Судалгааны баг)

Хэрэглэсэн малын тоо:

Асуулга судалгаанаас үзвэл зээл авсан болохоор хэрэгцээгээ бага зэрэг багасгасан гэсэн 1 өрхөөс бусад нь жилийн жилд байдаг хэмжээндээ л хэрэглэсэн байна. Арай бага хэрэглэсэн 3 өрхийн хувьд хүнсний хэрэглээ нь бидний тооцоолж байсан хэмжээнд байгаа бөгөөд үлдсэн 3 өрхийн хэрэглээ

арай их байна. Эдгээрийн 2 нь нас биед хүрсэн том хүүхдүүдтэй айлууд бөгөөд төслийн эхний жил малын тоо толгойд гарсан өөрчлөлт нь дараа жилүүдэд мал өсөхөд ихээхэн нөлөө үзүүлдэг тул хэрэглээний тал дээр сайтар анхаарч зохицуулах нь зүйтэй болов уу.

Зарж борлуулсан малын тоо:

Зарж борлуулсан малын тооны хувьд 1 өрхөөс бусад нь байж болох хэмжээний малыг зарсан байв. Гэвч энэ өрхийн хүнсний хэрэглээнээс гадна зарж борлуулсан малын тоо нь арай л их байв. Сумын төвд сургуульд сурдаг хүүхдүүдийн хоол хүнс, амьдралын зардалд зориулсан гэж байгаа боловч ийм их хэмжээний хэрэглээ нь цаашид мал өсгөх төлөвлөгөөгөө биелүүлэхэд саад болох тул ихээхэн анхаарах шаардлагатай юм.

6) Орлогын таамаг тооцоо

Асуулга судалгаан дээр үндэслэн төсөлд хамрагдсан малчин өрхүүдийн орлогыг дараахь байдлаар таамаглан тооцоолж болох юм.

Хүснэгт 4.6.19 Малчдын орлогын таамаг тооцоо (төг)

		Малчин А	Малчин В	Малчин С	Малчин D	Малчин E	Малчин F
Ноолуур	Зарсан хэмжээ	25	30	40	30	23	30
	Нэгж үнэ(төг/кг)	25,000	27,000 - 28,000	29,000 - 31,000	25,000 - 28,000	25,000	25,000
	Үүнээс олох орлого (төг)	625,000	825,000	1,200,000	795,000	575,000	750,000
Хонь(амьд)	Тоо толгой/орлого	2/60,000				23/690,000	
Ямаа(амьд)	Тоо толгой/орлого	2/50,000	2/75,000	5/167,500		4/60,000	3/50,100
Үхэр (амьд)	Тоо толгой/орлого				2/140,000		
Арьс(хонь)	Тоо ширхэг/орлого	1/8,000	2/14,000	10/90,000	3/18,000	5/25,000	2/10,000
Арьс(ямаа)	Тоо ширхэг/орлого	3/30,000	3/30,000	10/70,000	10/75,000	7/70,000	4/52,000
Арьс(үхэр)	Тоо ширхэг/орлого		1/3000				
Бусад (Ингэний сүү)					Сувиллын төсөл		105,000
Нийт		947,000	773,000	1,028,000	1,527,500	967,100	1,420,000

Хамгийн их орлого ноолуураас орсон байх бөгөөд төсөлд хамрагдсан өрхүүд 23-аас 40 кг ноолуур зарсан байна. Зарсан цаг үеэсээ шалтгаалан борлуулсан үнэ нь өөр өөр байх бөгөөд 3 сард үнэ нь хамгийн их өсөөд аажмаар буудаг байна. Малчид аль болох үнэ өндөртэй байхад нь зарахыг хүсдэг боловч төсөлд хамрагдсан малчдын хувьд хаврын хавсарганд ямаа хорогдохоос болгоомжлон, дулаарахыг хүлээсэн бөгөөд ихэнх нь 4-5-р саруудад зарсан. 6 өрхийн дотор ноолуураа хамгийн өндөр үнэд хүргэсэн айл нь 3 сарын сүүлээр 31000 төгрөгөөр зарсан байв. Ерөнхийдөө зээл авсан малчин өрхүүдийн бэлэн мөнгөний орлого өмнөх жилүүдийнхээс эрс өссөн байна.

7) Эхний жилийн ажлыг нэгтгэн дүгнэхэд

(Батлан даагч болон сумын Засаг захиргааны үүрэг)

"Малжуулах сан" төсөлд батлан даагчид чухал үүрэг гүйцэтгэх ёстой боловч бодит байдал дээр янз янз байна. Төсөлд хамрагдсан малчид батлан даагчдаасаа биет

хэлбэрийн тусламж дэмжлэг аваагүй байна. Батлан даагчийн тусламж дэмжлэг шаардлагагүй тул өнгөрсөн хугацаанд бараг уулзалдаагүй малчин байхад, мал услах, хариулах, ноос ноолуур самнах зэрэг өдөр тутмын ажилд батлан даагч нь тусалж дэмждэг малчин ч байна.

Нөгөө талаар сумын ЗДТГ-аас улирдалд 1 удаа, багийн дарга сард 1 удаа малчидаар явдагаас гадна, төсөлд хамрагдсан малчдыг Сумын удирдлага байнга эргэж тойрч, төслийн хэрэгжилтэд хяналт тавьдаг байна.

(Мал хуваарилалт)

Мал хэрхэн хуваарилагдах нь тэднийг зээлээр авч буй малчдын хувьд чухал ач холбогдолтой асуудал юм. Хэдийгээр холбогдох бүх хүмүүсийг оролцоотойгоор мал сонгох үйл ажиллагаа явагдсан боловч хэзээ хойно нь муу мал байна гэсэн гомдол гарч байсан. Ийм үед малаа худалдсан ба уг малыг нь авсан малчид суман дээр нүүр тулан уулзаж ярилцах байдлаар энэ асуудлыг шийдвэрлэсэн болно. Хойшид сумын захиргаа үүнээс сургамж авч, малыг малчдад хуваарилах үеэр хангалттай тайлбар таниулга хийх шаардлагатай.

(Төсөлд малчдын зүгээс өгч буй үнэлгээ)

Урьд жилийнхтэй харьцуулахад малын тоо толгой болон бэлэн мөнгөний орлого эрс нэмэгдсэн тул төслийг малчид маш өндрөөр үнэлж байна. Малынхаа тоо толгойг бодитоор өсгөснөөр өөртөө итгэлтэй болсон бөгөөд зээлээ хугацаанд нь хариуцлагатайгаар буцаан төлнө гэж ярьж байлаа.

Нөгөө талаар малчид орлого ороод ирвэл шууд зарцуулаад дуусгадаг, орлогоосоо бага багаар хуримтлал үүсгэх уламжлалгүй, бэлэн мөнгө байхгүй бол тэгээд байж л байдаг тул өвс тэжээл буюу өвс тэжээл авах мөнгийг зээлээр олгодог зохион байгуулалтыг цаашид үргэлжлүүлж явъя гэсэн хүсэлтийг ч тавьж байв.

(“Малжуулах сан” төсөлд сумын удирдлагаас өгч буй үнэлгээ)

Сумын Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ядуурлыг бууруулах”, “Малын чанарыг сайжруулах” зорилтуудтай энэ төслийн зорилго, үзэл санаа нийцэж байна гэж үзэж байгаа. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дээрхи зорилтуудыг тогтвортой биелүүлж явах суурь дэвсгэр тавигдлаа гэж ойлгож байна.

Мөн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцсон ЗДТГ-ын ажилтнууд тодорхой мэдлэг, туршлага хуримтлуулж, цаашид түүнийгээ ажилдаа бие даан ашиглаад явах чадвартай болсон.

Тэрчлэн, төсөлд хамрагдсан малчдын сэтгэл зүй, ажил, амьдралд хандах хандлага өөрчлөгдөж, хариуцлага өндөрсөж ирж буй нь бусад малчдад ихээхэн нөлөөлөл үзүүлж байна.

8) Малжуулах зээлийн 2 дахь жилийн хөрөнгө оруулалт

(Малын зээлийн буцаан төлөлт)

Хуваарийн дагуу 118 толгой мал буцаан төлөгдөх байсан боловч малчид зээлээ тоо ёсоор нь төлж, 26 мал буцаан өгөх байсан нэг малчин 40 болгож өгснөөр нийт 133 мал буцаан төлөгдсөн байна. Хуваариас давуулан өгсөн малчны хувьд энэ жил олон төл авч мал нь сайн өссөнөөс гадна цагийн байдал хүндрэх төлөвтэйг харгалзан боломжтой үедээ ахиухан буцаан төлөхөөр шийдсэн байна.

(Зээлд хамрагдах малчдыг сонгох үйл ажиллагаа)

Сумын удирдлага энэ жил хуваарийн дагуу буцаан төлөгдөх 118 толгой малыг 2 малчинд олгох чиглэлийг баримтлан зээлд хамрагдах малчдыг сонгох ажлыг зохион байгуулав. Ингэхдээ шалгаруулалтын 1-р шатанд 4 багт тус бүр 2 малчны нэрийг дэвшүүлж, багийн иргэдийн саналыг үндэслэн тус бүр 1 малчныг сонгон шалгаруулсан бөгөөд 2 –р шатанд сумын Засаг даргын дэргэдэх Малжуулах сангийн зөвлөл үлдсэн 4 малчны хоёрыг нь 2 дахь жилийн зээлд хамруулахаар сонгож авсан байна. Сонголт хийхдээ эхний жилийн сонголтын үр дүнд хийсэн дүгнэлтдээ үндэслэн "хариуцлагаа ухамсарлах чадвартай" гэсэн үзүүлэлтийг гол шалгуур болгон авсан байна.

Шинээр зээлд хамрагдсан малчдын малын тоо толгойн өөрчлөлтийг 4.6.20 дугаар хүснэгтэд харуулав. 2000, 2001 оны зудаар малаа их хэмжээгээр хорогдуулсан боловч өнгөрсөн хугацаанд бага багаар тогтвортой өсгөж ирснийг нь сонголт хийхдээ харгалзан үзсэн болно.

Хүснэгт 4.6.20 Шинээр зээлд хамрагдсан малчдын малын тоо, толгойн өөрчлөлт

	2000 он	2001 он	2002 он	2003 он	2004 он
Малчин Г	389	248	60	79	87
Малчин Н	75	98	26	34	50

(Зээлээр олгогдсон малын тоо)

Эхний жилийн зээлээс буцаан төлөгдсөн 133 толгой малыг шинээр зээлд хамрагдсан малчдад дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт 4.6.21 Зээл авахаас өмнөх ба зээл авсны дараах малын тоо

Малчин Малын тоо	Малчин Г			Малчин Н		
	Өөрт байсан мал	Зээлийн мал	Нийт	Өөрт байсан мал	Зээлийн мал	Нийт
Хонь	18	25(6)	43	3	37(25)	40
Ямаа	42	28(8)	70	20	41(22)	61
Үхэр	3	2(2)	5	6	0(0)	6
Адуу	20	0(0)	20	20	0(0)	20
Тэмээ	4	0(0)	4	1	0(0)	1
Нийт	87	55(16)	142	50	78(47)	128

() Төл малын тоо

Эхний жилд малын зээл авсан малчдад 100-гаад толгой мал олгосон бол 2 дахь жилийн хувьд малчин Г –д 55 толгой (төлтэйгөө 71 толгой) мал олгогдсон байна.

Энэ нь нэг талаар малчин G ийм хэмжээний мал байхад өсгөөд явж чадна гэж үзсэн, нөгөө талаар 2005 онд сумын хэмжээнд бэлчээрийн байдал муу байгаа тул зуд боллоо гэхэд гарч болох хохирлын хэмжээг аль болох бага байлгая гэж бодсоноос үүдсэн байна.

(Зээлээр олгосон малын байдал)

Шинээр зээлд хамрагдагч малчид сумын ХХАА-н түшмэлийн хамт урьд жилийн зээлийг буцаан төлөх малчны хотонд очиж, бэлдсэн малаас сонголт хийн тэмдэглээд, дараа нь очиж хүлээн авах байдлаар малын сонголтыг хийсэн болно. 2005 оны 11-р сарын байдлаар эдгээр мал хэвийн өсөн бойжиж байна.

4.6.3 Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах төсөл

(1) Зорилго ба үндсэн чиглэл

Эрдэнэ сумын ЗДТГ-ын харьяа Бүрдэнэ сувилал (хойшид сувилал гэх) нь бөөрний өвчин болон үе мөчний үрэвслийн өвчнийг монголын уламжлалт анагаах ухааны дагуу эмчлэх эмчилгээ явуулдаг сувиллын газар юм. Юуны өмнө, зуны улиралд нараар халсан элсэн манхны элсийг ашиглан хөлрүүлэх эмчилгээ хийдэг. Дараа нь алдагдсан шингэнийг нь тэжээллэг чанараар баялаг ингэний буцалгаа (цаашид хоормог гэх)-гаар нөхөж өгөх байдлаар энэхүү эмчилгээний 2 үе шатыг үр дүнтэйгээр хослуулан эмчилдэг байна. Энд Улаанбаатар, Сайншанд зэрэг төв суурин газрууд ба бусад аймгуудаас ч сувилуулагчид ирдэг тул зуны улиралд ингэний хоормогны тодорхой хэмжээний эрэлт хэрэгцээ үүсдэг. Сум, сувилуулагчдад нийлүүлэх ингэний хоормогийг хавь орчны малчдаас худалдан авдаг.

Ингэж Бүрдэний сувиллын газарт сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах нь ойролцоох малчдын бэлэн мөнгөний орлого олох чухал эх үүсвэр болж байна. Иймээс сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах боломжийг нэмэгдүүлснээр орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлж, эцсийн байдлаар малчдын амьжиргааны түвшин сайжрахад хувь нэмэр оруулна. Мөн сувиллын газрын хувьд малчдаас сүү, сүүн бүтээгдэхүүнийг тогтмол худалдан авч чадвал менежмент, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах боломжтой. Ийм замаар малчид болон сувиллын газрыг бэхжүүлэх нь уг төслийн зорилго юм.


Энэхүү төсөл нь дараахь 3 үндсэн чиглэлтэй байна. Үүнд: 1-рт, бэлчээрийг улирлаар хуваарьтай ашиглах уламжлалт аргын хүрээнд сүүг цуглуулна. Сүү цуглуулахын тулд хөгжингүй орнуудад хөгжсөн эрчимжсэн фермерийг байгуулалгүйгээр нүүдлийн мал аж ахуйн онцлогт үндэслэсэн хагас эрчимжсэн системийг ашиглана.

2-рт, Говь нутагт цөөрөх хандлагатай байгаа тэмээний хэвийн өсөлтийг хангах. Өндөр өртөгтэй ноолуурыг гаргадаг ямаа руу хэлбийчихсэн мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын байдлыг сайжруулан, говийн экологийн орчинд тохирсон тэмээний тоог нэмэгдүүлнэ.

3-рт, сумын төв болон аймгийн төв зэрэг хүн ам ихтэй газар руу төвлөрөх хандлагатай байгаа үйлдвэрлэлийн тогтолцоог залруулж, цаашид эдгээр төв суурингаас алслагдсан газарт борлуулалтын тулгуур газрыг бий болгоно. Бүрдэний сувиллын газрын сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтын төслийг бэлчээр ашиглалт, худаг байгуулалт ба менежментийн төсөлтэй нягт уялдаа холбоотой хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Иймд сумын төвөөс 32 орчим км, аймгийн төвөөс 80 орчим км-ын зайд орших алслагдсан бага ашигладаг бэлчээрийг үр ашигтай ашиглах нь төслөөс баримтлах үндсэн чиглэлийн нэг болно.

(2) Төслийн хэрэгжилтийн бүтэц, зохиогн байгуулалт

Дээр өгүүлсэн чиглэлийг төслийн бүтэц зохион байгуулалт болгож, дараах зурагт харуулав. Энэхүү төслийн хэрэгжилтэд малчид ба сумын ЗДТГ-ын хамтын үйл ажиллагаа зайлшгүй чухал юм.



(3) Төслийн төлөвлөлтийн агуулга

1) Борлуулах сүүн бүтээгдэхүүн ба төлөвлөж байгаа тоо хэмжээ

Малчид Бүрдэний сувиллын газарт голдуу буцалгаа болгож боловсруулсан ингэний сүүг борлуулдаг. Үүнээс гадна ямааны сүү, үхрийн сүү, бяслаг зэргийг борлуулна. 2003 оны борлуулалтын гүйцэтгэл болон 2004 онд боловсруулах ингэний сүүн бүтээгдэхүүний хэмжээг дараахь хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4.6.22 2003 онд борлуулсан ингэний сүү болон 2004 оны борлуулалтын төлөвлөгөө

	2003 оны гүйцэтгэл	2004 оны төлөвлөгөө
Нэг хүний 1 өдөрт хэрэглэх сүүний хэмжээ(л)	0.75	1.5
Сувилуулагчдын тоо (дундаар)	30	40
Ажиллах өдрийн тоо	45	45-60
Боловсруулахаар төлөвлөсөн сүүний хэмжээ(л)	1013	2700-3600

2004 оны нэг хүний нэг өдөрт хэрэглэхээр төлөвлөсөн сүүний хэмжээг 2003 оны гүйцэтгэлтэй харьцуулвал 0.75 литрээс 1.5 литр болж нэмэгдсэн байна. Энэ нь сувиллын газрын бөөрний өвчний эмчилгээнд хэрэглэдэг буцалгааны хэмжээ 2003 он хүртэл хүрэлцээгүй байсныг бүрэн сайжруулахаар шийдсэнтэй холбоотой юм. Эрдэнэ сум цаашдаа нэг хүний нэг өдөрт боловсруулах сүүний хэмжээг 3.0 литр хүртэл нэмэгдүүлэх чиглэлийг баримтлаж байна. Бүрдэнийн сувиллын газрын эмчилгээнд наранд хангалттай бүлээссэн элсийг хэрэглэдэг тул ажиллах хугацаа нь цаг уурын нөхцөлөөс ихээхэн хамаардаг. Иймээс ажиллах дээд хугацааг 60 хоногоор тооцож байгаа боловч цаг уурын нөхцлөөс хамаарч 45 хоног болж болзошгүй юм.

2) Үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөө

2003 оны намар ЖАЙКА-ын байгуулсан Бүрдэний шинэ худаг нь бага ашигладаг бэлчээрт дахин өвөлжөө барих боломжийг нээсэн ба нөгөө талаар малчдын тус нутагт орших сувиллын газар руу тэмээний сүү, сүүн бүтээгдэхүүнийг борлуулах тулгуур газрыг бий болгох ба үйлчлүүлэгчдийг усаар хангах гэсэн олон талын ашиглалтыг урьдчлан тооцсон болно. Ялангуяа малчдын ингэний буцалгааны борлуулалтын үүднээс харвал борлуулах газар болох сувиллын газар, үйлдвэрлэл явуулах тулгуур газраар ашиглагдах худаг хоорондын зай ихээхэн ойртсон байна. Сувиллын газрын хувьд эмчилгээнд хэрэглэх тэмээний сүүний байнгын дутагдлыг шийдвэрлэж сүүний хэмжээг нэмэгдүүлэх сонирхолтой байна. Иймээс энэ худгийг байгуулснаар улам олон малчид үйлдвэрлэлийн тулгуур газар рүү төвлөрч, сувиллын газарт нийлүүлэх сүүний хэмжээ нэмэгдэх гэсэн үр дүн хүлээгдэж байлаа.

Гэвч малчидтай хийсэн ярилцлагаар дамжуулан сувиллын газар, үйлдвэрлэлийн төв болох худаг хоорондын зай ойртсоныг дуртайяа хүлээн авч байгаа ч тэнд цугларах малчдын тоо маш хязгаарлагдмал байх ба цаашилбал сувиллын газрын

ихэнх малчдад борлуулалт хийх сонирхолтой газар болоогүй байгаа нь тодорхой болов. Малчид сувиллын газарт борлуулалт хийхэд тийм ч их идэвхтэй байхгүй байгаа шалтгаан нь тэмээний сүү худалдаж авах үнэтэй холбоотой. Тэмээний сүүг борлуулах боломж ерөнхийдөө ховор байдаг ба зах зээлд 700 төгрөгөөр, бусад сүүнээс өндөр үнээр борлодог байхад сувиллын газарт 450 төгрөгөөр (2003 оны гүйцэтгэл), тун бага үнээр худалдан авч байсан.

Ийм учраас сувиллын газар шаардлагатай хэмжээний сүү авахын тулд малчдаас авах сүүний үнийг нэмэх асуудлыг авч үзэх нь зайлшгүй боллоо. Нөгөө талаар Бүрдэнийн сувиллын газар үйлчлүүлэгчдэд зориулсан байгууламжийн ашиглалтын төлбөрийг 2500 төгрөгөөр буюу бага үнээр тогтоосон байсан тул зардлуудыг багасгахаас өөр аргагүй байв. Үйлчилгээний төлбөрийг багаар тогтоосны хувьд ижил төрлийн бусад газраас барилга байшин тааруухан, бусад сувиллын газартай өрсөлдөхийн тулд үнийг бууруулах шаардлагатай байснаас тэр юм байна. Гэвч ингэснээр тэмээний сүүг худалдан авах үнэ бага болж, дээр дурдсанчлан малчид Бүрдэнэ дээр борлуулалт хийх сонирхолгүй болно. Мөн сувиллын газрын хувьд эмчилгээ үйлчилгээнд шаардлагатай хангалттай хэмжээний сүүг хэзээ ч авч чадахгүй гэсэн менежментийн хувьд яах ч аргагүй байдалд орж байсан байна.

Ийм байдлыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээг авах талаар Эрдэнэ сумтай зөвлөлдөж, нягтлан судалснаар өмнө нь жил бүр хийгдэж ирсэн байгууламжийн засвар зэрэг барилга байшин болон холбогдох байгууламжийг бэхжүүлэх нь хэдий чухал ч байгаль орчны онцлог бүхий Бүрдэнэ дээр хийлгэх эмчилгээ гэсэн тухайн сувиллын газрын онцлог давуу талыг эн тэргүүний ээлжинд таниулж, тэмээний буцалгааны хэмжээг нэмэх зэрэг үйлчилгээг улам сайжруулах чиглэлийг баримталсны үндсэн дээр дараах шийдвэрийг гаргав.

- Сувиллын газарт хангалттай хэмжээний сүү авахын тулд малчдаас борлуулалт хийх сонирхолтой түвшинд үнийг тогтоох шаардлагатай тул өмнө нь худалдан авч байсан үнэ болох 450 төгрөгийг 650 төгрөг болгон нэмэх.
- Бүрдэнэ нь төмөр замд ойр байрладаг, байгалийн элсэн манхан бүхий үзэсгэлэнт байгальтай ба түүний элсийг эмчилгээнд хэрэглэдэг зэрэг сувиллын газрын хувьд байршлын олон давуу талтай тул үйлчлүүлэгчдээс авах үйлчилгээний үнийг 2500 төгрөгөөс 3500 төгрөг болгон нэмэх.
- Сумын захиргаа Бүрдэнийн сувиллын газрын сурталчилгааны ажлыг өмнөхөөсөө улам идэвхтэй явуулж, байнгын үйлчлүүлэгчидтэй болгоно. Мөн малчдад төлөвлөж байгаа үйлчлүүлэгчдийн тоог урьдчилан мэдэгдэж, шаардлагатай сүүний хэмжээний талаар мэдээлэл өгөх.

3) Төслийн орлого, зарлагын тооцоо

Сувиллын газрын орлого, зарлагын урьдчилсан тооцоог доор үзүүлэв.